



2025 оны 09 дугээр сарын 02  
№35 (1380)

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН  
МЭДЭЭЛЭЛ



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

213.	“Түмэн айл нөөц” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын даргад холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0020	1707
214.	“Эйкусора” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Дорноговь аймгийн Татварын газар, Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0058	1716
215.	“МИГ даатгал” ХХК-ийн гомдолтой, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч М.Тамирт холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0063	1725
216.	Д.Сайнбилэгийн нэхэмжлэлтэй, Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0064	1737
217.	Д.Галбаатарын нэхэмжлэлтэй, Архангай аймгийн Засаг дарга, тус аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тус тус холбогдох захиргааны хэргийн тухай	Дугаар 001/ХТ2025/0066	1748

۲۷۰

رسول نبی سلیمان میرزا خوشبو بادیعین خیر  
رشید نام پیغمبر و حضرت مسیح کشمیر و حضرت مسیح شریعت

جی ۴۰  
«عیدم سلیمانی نظریت» نہ۔ وہ۔ — تکمیل  
بنیادیں ملن۔ سسنسیو پیشیں۔ نسلیں میں  
مہمیں قی نسلیں عارضیں کی پیشہ کیوں  
تکمیل و نسلی عارضیں

جی ۶ .  
جی ۷ .

۴ - بسندوختن گام نزدیکیا مل . وکیل‌دهی  
مذکورین تاریخ دیسر صفتمندی خود پیوچه سکون درستند  
لذت گم حصل

۵ - نیوششمند گام نزدیکیا مل . بعده سشن  
بسندیم گم سپس مذکوری . همای بادیوی گم تاریخ  
بیوق تاریخ دیسر صفتمند گام نزدیکیا خود  
همای حمله نیوششمند گذشتار ف نیکی هر حسن

۰۰۴/۰۰۳ - ۰۰۲/۰۰۱ - ۰۰۰/۰۰۱

۲۰۶

九章賦

三

۹۵

二

۹۷۶۰۰/۱۴۱ : مکالمہ

۲۳



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 02 дугаар  
сарын 17-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0020

Улаанбаатар  
хот

“Түмэн айл нөөц” ХХК-ийн нэхэмжлэлтэй,  
Ашигт малтмал, газрын тосны газрын даргад  
холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:	Г.Банзрагч
Шүүгчид:	Д.Батбаатар
	М.Батсуурь
	Ц.Цогт
Илтгэгч шүүгч:	П.Соёл-Эрдэнэ
Нарийн бичгийн дарга:	Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ2024/0616 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 221/МА2024/0753 дугаар магадлалтай,

Хэргийн оролцогчид: нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Н.Наранбаяр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Эрдэнэболд нарыг оролцуулан,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 49 дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, “шүүхийн хууль хэрэглээний зөрууг арилгах” эсэх, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэх үндэслэлээр, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдоор хянан хэлэлцэв.

### ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага: Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/39 дүгээр тушаалын СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайд холбогдох хэсгийг хүчингүй болгуулах, хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулалтын үнэлгээг нэгтгэн гаргаж, холбогдох дүгнэлт гаргахыг Сонгон шалгаруулалтын комисст даалгах;

2.Хэргийн нөхцөл байдал: Ашигт малтмал, газрын тосны газрын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хайгуулын сонгон шалгаруулалтыг зарлах, “Түмэн айл нөөц” ХХК нь СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайн сонгон шалгаруулалтад оролцсон, 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг нээсэн байна. Гэвч 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн A/39 дүгээр тушаалаар “Засгийн газрын 2023 оны 268 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг санал дүгнэлт гарган танилцуулах хүртэл” гэх үндэслэлээр уг сонгон шалгаруулалтыг хүчингүй болгосон байна.

3.Нэхэмжлэгчээс: “... сонгон шалгаруулалтад хөндлөнгөөс нөлөөлж байгаа, сонгон шалгаруулалтын техникийн үнэлгээнд аж ахуйн нэгжүүд нэг их зөрөөтэй оноо авдаггүй, ерөнхийдөө ойролцоо, гол нь үнийн санал гэдэг бол компаниудын нууц байдаг, сонгон шалгаруулалт нэгэнт зарлагаад сонгон шалгаруулалтын материал нээсэн бол хөндлөнгөөс сонгон шалгаруулалт зарласан байгууллага оролцож хүчингүй болгож, дундаас нь зогсоодог эрх хэмжээ огт байхгүй, бусад аж ахуйн нэгжүүд хүртэл цахимаар ороод ямар үнийн санал болон техникийн санал өгсөн гэдгийг үзэж хараад мэдэх боломжтой болсон, дахин сонгон шалгаруулалт зарлахад бусад компаниудын нууцыг мэдсэн учраас өрсөлдөх боломжийг хязгаарласан хууль бус тушаал гарсан тул хүчингүй болгох ёстой” гэж,

4.Хариуцагчаас: “... Засгийн газрын тогтоолоор батлагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайд багтсан эсэх талаар няяглан шалгахаар хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг санал, дүгнэлт гарган танилцуулж нийтэд мэдээлэх хүртэл сонгон шалгаруулалтыг түр хойшлуулсан нь Ашигт малтмал, газрын тосны газрын даргын бүрэн эрхийн асуудал, сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжүүдээс төлсөн босго үнийн төлбөрийг буцаан олгохоор шийдвэрлэсэн тул сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгжүүдэд хохирол учраагүй, Баянхонгор аймгийн ард иргэд санал, гомдол гаргасан, нэхэмжлэг шалгараагүй тул эрхийг нь зөрчөөгүй” гэж тус тус маргажээ.

5.Анхан шатны шүүх дараах үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн. Үүнд:

5.1.Хуульд заасан хайгуулын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих чиг үүргийн хүрээнд Ашигт малтмал, газрын тосны газрын дарга нь сонгон шалгаруулалттай холбоотой аливаа шийдвэрийг хянах, хүчингүй болгох эрх хэмжээтэй. Маргаан бүхий Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн A/39 дүгээр тушаалын 1 дэх заалтаас үзвэл энэхүү захиргааны актын зорилго нь СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайн кодтой сонгон шалгаруулалт нь Засгийн газрын 2023 оны 268 дугаар тогтоол



болон бусад хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг хянах агуулгатай байна. Хэрэгт авагдсан баримтаас үзвэл ... Засгийн газрын 2023 оны 268 дугаар тогтоолд нийцээгүй гэж үзэх үндэслэлгүй.

5.2.Хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газар тухайн талбай байрших аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын санал авах ажиллагааг тухайн үед хийсэн болох нь тогтоогдож байна. Энэхүү санал авах ажиллагааны дагуу Баянхонгор аймгийн Засаг даргын ирүүлсэн санал нь хуульд заасан үндэслэлээр татгалзсан хариу гэж үзэх үндэслэлгүй байсан тул хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газраас ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох талбайн солбицлыг тодорхойлон ... хайгуулын тусгай зөвшөөрөл олгох талбайн солбицолд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

5.3.Сонгон шалгаруулалтын талбайг баталсан нь Баянхонгор аймгийн иргэдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй гэх нөхцөл байдал хаваст хэрэгт авагдсан баримтаар тогтоогдоогүй тул захиргааны байгууллагын Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 26.2-т заасан захиргааны акт батлан гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж болзошгүй этгээдээс тайлбар, санал авах ажиллагааг хэрэгжүүлээгүйг зөвтгөх үндэслэл болохгүй.

6.Давж заалдах шатны шүүх дараах үндэслэлээр шийдвэрийг хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Үүнд:

6.1.Хариуцагч Ашигт малтмал, газрын тосны газар нь маргаан бүхий “СШ-66” дугаартай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтыг зарлахдаа Усны тухай хуульд заасны дагуу тус сав газрын захиргаанд мэдэгдээгүй, санал аваагүй болох нь тогтоогдож байх тул ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалтын ажиллагаа нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэхийг дахин шалгах зорилгоор СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайд зарлагдсан сонгон шалгаруулалтыг хүчингүй болгосон хариуцагчийн шийдвэрийг буруутгаж болохгүй.

6.2.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт дуусаагүй буюу Сонгон шалгаруулалтын комиссоос ялагчаар шалгаруулсан тухай дүгнэлт гаргаагүй, захиргааны байгууллагаас хуульд заасан ажиллагааг хийсний үндсэн дээр сонгон шалгаруулалт зарлах энэ тохиолдолд маргаан бүхий тушаалын улмаас нэхэмжлэгч “Түмэн айл нөөц” ХХК-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн, зөрчигдөж болзошгүй нөхцөл байдал үүссэн гэж үзэхээргүй юм.

6.3.Учир нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгоход дээрх байдлаар Ашигт малтмалын тухай болон бусад хуульд заасан тодорхой

шаардлагыг хангасан тохиолдолд сонгон шалгаруулалтын журмаар олгох зохицуулалттай бөгөөд захиргааны байгууллагаас энэхүү шаардлага хангагдсан эсэхийг дахин хянаж үзэх нь зүйтэй гэж үзсэн шийдвэр нь нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй байна.

7. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1. Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4-т заасны дагуу сонгон шалгаруулалт явуулахаас 30-аас доошгүй хоногийн өмнө сонгон шалгаруулалтын урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлах үргийн дагуу нийтэд мэдээлсэн. Гэтэл энэ үргийн дагуу нийтэд зарлаж байгаа зохион байгуулалтын шинжтэй захиргааны байгууллагын үйлдлийг давж заалдах шатны шүүх “сонгон шалгаруулалтыг зарлах, хүчингүй болгох бүрэн эрх” гэж тайлбарлаж байгаа нь хууль тогтоогчийн хүсэл зорилгод нийцэхгүй, хууль зүйн үндэслэлгүй байна. Хэрэв Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Ашигт малтмалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн дагуу талбайн ялгалт хийж зарлагдсан сонгон шалгаруулалтыг үнэлгээний шатанд нь хүчингүй болгох бүрэн эрхтэй гэж үзвэл сонгон шалгаруулалтын үндсэн зарчим алдагдахаар байна.

7.2. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.26-д заасан чиг үүргийг эрх бүхий этгээд нь сонгон шалгаруулалт зарлахаас өмнө хэрэгжүүлж, давхцалыг шалгасан байдаг ба ... давж заалдах шатны шүүхийн дүгнэлт үндэслэлгүй. СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай сонгон шалгаруулалтын талбай нь сонгон шалгаруулалт явуулахыг хориглосон талбайтай давхцалгүй болох нь хариуцагчийн тайлбар, хэргийн үйл баримтаа тогтоогдсон.

7.3. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд зөвхөн сонгон шалгаруулалтын зарчмаар шийдвэрлэхээр хууль тогтоогчийн хүсэл зориг илэрхийлэгдэнэ. Гэтэл давж заалдах шатны шүүхээс Ашигт малтмал, газрын тосны газрын дарга сонгон шалгаруулалт хууль тогтоомжийн хүрээнд явагдаж байгааг хянах, шалгах эрхтэй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй.

7.4. Давж заалдах шатны шүүх ашигт малтмал хайгуулын тусгай зөвшөөрлийг Ашигт малтмалын тухай хууль болон бусад хуульд заасан тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд сонгон шалгаруулалтын журмаар олгох зохицуулалттай бөгөөд захиргааны байгууллагаас энэхүү шаардлага хангасан эсэхийг дахин хянаж үзэх нь зүйтэй гэж үзсэн сонгон шалгаруулалтыг хүчингүй болгох эрхтэй гэсэн хууль зүйн дараалалгүй дүгнэлт хийсэн.



7.5. Захиргааны байгууллагаас тухайн талбайд сонгон шалгаруулалт явуулах нь хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг бүрэн дүүрэн шалгасны үндсэн дээр сонгон шалгаруулалт зарлагдана. Ийнхүү бүрэн дүүрэн шалгасан учраас сонгон шалгаруулалт нь хуульд заасан шаардлагыг хангаж явагдаж байгаа гэсэн сонгон шалгаруулалтад оролцогч аж ахуйн нэгжийн итгэл хамгаалагдах ёстай.

7.6. Маргаан бүхий захиргааны акт зорилгодоо нийцээгүй, бодит нөхцөл байдлыг тогтоогоогүйгээр хийсвэр таамаглалд үндэслэн гарсан. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сонгон шалгаруулалт нь Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 268 дугаар тогтоол болон бусад хууль тогтоомжид нийцээгүй гэх тушаалын үндэслэл нь нотлох баримтаар тогтоогдоогүй болно гэжээ.

#### ХЯНАВАЛ:

8. Анхан болон давж заалдах шатны шүүхээс хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн байх тул шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, маргаан бүхий тушаалын СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайд холбогдох хэсгийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, дахин шинэ акт гаргахыг хариуцагчид даалгав.

9. Тогтоогдсон үйл баримтын тухайд,

10. Ашигт малтмал, газрын тосны газар нь 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдөр СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл авах сонгон шалгаруулалт зарласан, 2024 оны 03 дугаар сарын 11-ний өдөр сонгон шалгаруулалтад оролцогчдын материалыг нээхэд “Түмэн айл нөөц” ХХК хамгийн өндөр үнийн санал<sup>1</sup> гаргасан байсан, 5 хоногийн дотор техникийн үнэлгээг гаргах байсан боловч 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдөр уг сонгон шалгаруулалтыг “хууль тогтоомжид нийцэж буй эсэхийг тодруулах” гэсэн үндэслэлээр хүчингүй болгосон.

11. Энэхүү маргааны тухайд хяналтын шатны шүүхээс шийдвэрлэж, хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь хайгуулын сонгон шалгаруулалт зарлахаас өмнө Усны сав газраас санал авах үүрэгтэй эсэх, захиргаа нэгэнт зарласан сонгон шалгаруулалтыг үнийн санал нээсний дараа хүчингүй болгох эрхтэй эсэх тухай байна.

12. Хууль хэрэглээний хувьд:

13. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага

<sup>1</sup> 1 дэх хавтаст хэргийн 131 дүгээр талд



дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ” гэж, 11.1.26-д “энэ хуулийн 9.1.11-д заасан талбайд сонгон шалгаруулалт явуулахыг хориглосон талбай давхцаж байгаа эсэхийг шалгаж, давхацсан бол тухайн хэсгийг хасаж, мэдээллийг Үндэсний геологийн албандаа хүргүүлэх” гэж заасныг маргааны үйл баримтад холбогдуулан хэрэглэхэд, захиригааны байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргээ бүрэн дүүрэн хэрэгжүүлээгүй буюу сонгон шалгаруулалтаар олгох талбай нь хориглосон талбайтай давхцаж байгаа эсэхийг бүрэн шалгаж тодруулаагүй буруутай байна.

14.Учир нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т “Тухайн сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгоход тус сав газрын захиригааны саналыг үндэслэнэ” гэж зааснаас үзэхэд хайгуулын тусгай зөвшөөрлийн сонгон шалгаруулалт зарлахаас өмнө усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх мэргэжлийн чиг үүрэг бүхий байгууллага болох Усны сав газраас урьдчилан санал авсан байх нь “хориглосон талбайн давхцал шалгах” гэсэн Ашигт малтмалын тухай хуулийн агуулгад хамаарахаар байна.

15.Тодруулбал, сонгон шалгаруулалтаар олгох талбай нь гол, мөрөн, нуур, усны эх үүсвэр болон газрын доорх цэнгэг усны орд газартай давхцаагүй байхаас гадна эдгээрт нөлөөлөх сөрөг нөлөөгүй талаар мэргэжлийн байгууллагаас дүгнэлт гарсны эцэст сонгон шалгаруулалтыг зарлахаар байна.

16.Гэтэл Ашигт малтмал, газрын тосны газар нь маргаан бүхий сонгон шалгаруулалтыг зарлахдаа Усны сав газраас санал аваагүй, улмаар энэхүү алдааг засах шаардлагатай гэж тайлбарлаж байгаа тохиолдолд Захиригааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-д “шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжоос хэтэрсэн гэж үзвэл захиригааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиригааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлэх” гэж зааснаар маргаан бүхий тушаалыг баруун хугацаагаар түдгэлзүүлж, хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

17.Өөрөөр хэлбэл, хариуцагч сонгон шалгаруулалт зарлахаас өмнө хуульд нийцүүлэн талбайн солбицол тогтоох үүргээ хэрэгжүүлээгүй буруутай байгаа хэдий ч өөр бусад үндэслэлээр, тухайлбал, Усны асуудал хариуцсан мэргэжлийн байгууллагаас ирэх саналаас хамаарч, маргаан бүхий актын эрх зүйн үр дагавар өөр байж болох буюу хэрэв татгалзсан санал ирвэл маргаан бүхий тушаал хууль ёсны болох, харин татгалзсан санал ирээгүй бол маргаан бүхий тушаал хууль бус болох үр дагавар



үүсэх бөгөөд энэхүү нөхцөл байдлыг тодруулах, дутуу ажиллагааг нөхөн гүйцээх нь хариуцагчийн хуулиар хүлээсэн чиг үүрэгт хамаарч байх тул шүүхийн шинжлэн судлах хүрээнээс хэтэрсэн байна.

18. Түүнчлэн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдрийн 58 дугаар тогтоолоор “Хил хязгааргүй алхам төв” НҮТББ-ын нэхэмжлэлтэй, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцэж, “... ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг олгох сонгон шалгаруулалтыг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулсан маргаан бүхий журмыг батлахдаа Усны сав газарт ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтын журмаар олгох тохиолдолд нарийвчилсан хуулийн дээрх зохицуулалт, шаардлагыг орхигдуулсан, энэ нь Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасантай нийцээгүй талаарх шүүхийн дүгнэлт үндэслэлтэй” гэж дүгнэж, сонгон шалгаруулалтын журмын холбогдох зохицуулалтыг дахин шинээр журам гаргах хүртэл 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэсэн байdag.

19. Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.26-д заасан “сонгон шалгаруулалт явуулахыг хориглосон талбай” гэдгийг, мөн хуулийн 17 дугаар зүйлийн 17.5-д заасан “Энэ хуулийн 17.4-т заасны дагуу ялгасан талбай нь дараах шаардлагыг хангасан байна: 17.5.2-т “тусгай хэрэгцээний газар, ашигт малтмал хайх, ашиглахыг хориглосон газар, нөөцөд авсан талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх”, 17.5.3-т “хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайтай ямар нэг байдлаар давхцаагүй байх” гэсэн зохицуулалтад хамааруулан ойлгох бөгөөд энэхүү маргааны тохиолдолд усны асуудлаар ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох нөхцөл байдал байгаа эсэхийг шалгах нь маргаан бүхий акт хууль ёсны эсэхэд нөлөөлөхөөр байна.

20. Иймээс Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.26-д заасан ажиллагаанд “Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2-т заасан ажиллагаа хамаарна” гэсэн агуулгаар хууль хэрэглээний нэгдмэл байдал тогтоох нь зүйтэй.

21. Мөн Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 111 дүгээр тогтоолоор Н.Цэдэнбал, Д.Жигжид нарын нэхэмжлэлтэй, Ашигт малтмал, газрын тосны газрын Геологи, уул уурхайн кадастрын хэлтэст холбогдох захиргааны хэргийг хянан хэлэлцэж, “... Ашигт малтмалын тухай хууль нь ашигт малтмалын холбогдох үйл ажиллагааны үндсийг бүрдүүлэхээс гадна дээр дурдсан хүрээлэн буй орчин болон хүний эрхэд учирч болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх зорилгыг өөртөө агуулж, уг зорилгод нийцсэн урьдчилсан нөхцөл, шаардлагуудыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгоход тавигдахаар зохицуулсан байна. ...

Энэ хүрээнд анхан шатны шүүх хариуцагч нь сав газрын захиргаанаас усны нөөцтэй холбоотой саналыг аваагүй, экологийн хохирлыг нөхөн сэргээхэд ашигт малтмалын нөөцийн үнэлгээ хүрэлцэх эсэхийг тодруулаагүй нь нэхэмжлэгч нарын экологийн тэнцвэр алдагдахаас хамгаалуулах эрхэд хамааралтай гэж дүгнэсэн нь үндэслэлтэй” гэж дүгнэж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангасан байна.

22.Ашигт малтмал, газрын тосны газрын 2021 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 8/1946 дугаар албан бичгээр Баянхонгор аймгийн Засаг даргад хандаж, сонгон шалгаруулалтаар олгох боломжтой талбайн саналыг хүргүүлсэн, уг албан бичгийн хариуд “... сонгон шалгаруулалт зарлах газруудад нутгийн иргэдийн тахилгат уул, малчдын өвөлжөө, хаваржааны эзэмшил газар, бэлчээр, уст цэг, булаг, шанд олноор хамрагдаж байгаа<sup>2</sup> тул дэмжих боломжгүй” гэж татгалзсан санал хүргүүлснээс үзэхэд усны асуудлыг дахин нягтлах шаардлагатай, тухайн бүс нутгийн усны нөөц хомсдох эсэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл үүсэх эсэх, ус ашиглах боломжит хэмжээний талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг урьдчилан гаргуулах нь хуулийн дээрх зохицуулалтад нийцэх юм.

23.Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.13-т “тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалт зохион явуулах ...” гэж, 11.1.14-т “хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй холбоотой үйл ажиллагаанд нэгдсэн хяналт тавих” гэж тус тус заасан тул сонгон шалгаруулалт зохих журмын дагуу явагдаагүй тохиолдолд хүчингүй болгох эрхтэй, хэрэв усны хууль тогтоомж зөрчигдэж, хохирол нөхөн сэргээгдэхгүй, байгаль орчин, нийтийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхөөр байвал тухайн газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болохгүй үр дагавар үүсэх тул нэхэмжлэгчийн “сонгон шалгаруулалтын материал нээсэн бол хөндлөнгөөс нөлөөлж, хүчингүй болгож, дундаас нь зогсоох эрхгүй” гэх гомдоор маргаан бүхий актыг шууд хүчингүй болгох үндэслэлгүй байна.

24.Энэхүү шүүхийн тогтоолыг биелүүлэх арга журам, үүсэх үр дагаврын тухайд:

25.Захиргааны байгууллагаас хуульд нийцүүлэн холбогдох ажиллагааг хийж, эрх бүхий мэргэжлийн байгууллагаас санал, дүгнэлт авсны дараа, уг саналыг үндэслэн усны хууль тогтоомж зөрчигдэх, нөхөн сэргээгдэх боломжгүй үр дагавар үүсэхгүй, түүнчлэн хориглосон талбайтай давхцахгүй бол тухайн талбайд зарласан сонгон шалгаруулалт хууль ёсны болох ба энэ тохиолдолд нэхэмжлэгчийн эрх түрүүлж хамгаалагдах тул сонгон шалгаруулалтыг дахин шинээр зарлах биш, харин үргэлжлүүлж, техникийн саналыг үнэлж, Сонгон шалгаруулалтын комисс нэгдсэн дүгнэлт гаргах замаар шүүхийн шийдвэрийг биелүүлнэ.

<sup>2</sup> 1 дэх хаваст хэргийн 111, 109 дүгээр талд



26.Дээрх үндэслэлүүдээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, нэхэмжлэгчийн гомдолын зарим хэсгийг хангаж шийдвэрлэлтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.1, 127.2.2-т заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 08 дугаар сарын 08-ны өдрийн 128/ШШ2024/0616 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 221/МА2024/0753 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг “Ашигт малтмалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.26, Усны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-д заасныг баримтлан нэхэмжлэгч “Түмэн айл неөц” ХХК-ийн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/39 дүгээр тушаалын СШ6605, СШ6615, СШ6625 дугаартай талбайд холбогдох хэсгийг 6 сарын хугацаагаар түдгэлзүүлж, дахин шинэ акт гаргахыг хариуцагчид даалгасугай. 2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.6-д зааснаар шүүхээс тогтоосон хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй бол уг маргаан бүхий А/39 дүгээр тушаалын холбогдох хэсэг хүчингүй болохыг дурдсугай” гэж өөрчилсүгэй.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчийн улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ

Г.БАНЗРАГЧ

ШҮҮГЧИД

Д.БАТБААТАР

М.БАТСУУРЬ

Ц.ЦОГТ

П.СОЁЛ-ЭРДЭНЭ

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 09-ний өдөр

Дугаар 001/ХТ2025/0058

Улаанбаатар  
хот

“Эйкүсора” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Дорноговь  
аймгийн Татварын газар, Дорноговь аймгийн  
Даланжаргалан сумын Засаг даргад холбогдох  
захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн  
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч шүүгч:	Х.Батсүрэн
Танхимын тэргүүн:	Д.Мөнхтуяа
Шүүгчид:	Г.Банзрагч
	П.Соёл-Эрдэнэ
Илтгэгч шүүгч:	Ц.Цогт
Нарийн бичгийн дарга:	Б.Энхжаргал

Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн  
2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 115/ШШ2025/0004 дүгээр шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03  
дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0225 дугаар магадлалтай,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт  
шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 231  
дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой захиргааны хэргийг нэхэмжлэгчийн  
итгэмжлэгдсэн төлөөлөгч Г.Ижилцэцэг, хариуцагч Дорноговь аймгийн  
Татварын газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Мөнхсарнай, хариуцагч  
Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын итгэмжлэгдсэн  
төлөөлөгч М.Отгонбат, Н.Оюунгэрэл нарыг оролцуулан, нэхэмжлэгчийн  
итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг  
үндэслэн хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1.Нэхэмжлэлийн шаардлага:

1.1.Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын 2024  
оны 06 дугаар сарын 11-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 01/343 дугаар  
албан бичгийг хүчингүй болгуулах,



1.2.Дорноговь аймгийн Татварын газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн “Өр хураах үйл ажиллагаа явуулах тухай” 01/147 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах.

Хэргийн нэхцэл байдал:

2.Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн А/138 дугаар захирамжаар тус сумын нутаг дэвсгэрт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч “Эйкүсора” ХХК-д уурхайн ашиглалтын зориулалтаар 13.148 (MV-020420), 59.6112 (MV-020421), 193.3873 (MV-020421), 1781.3827 (MV-020421), 72.6566 (MV-020419), 129.8518 (MV-020419) га газрыг эзэмшүүлжээ.

2.1.Дорноговь аймгийн Татварын газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн “Өр хураах үйл ажиллагаа явуулах тухай” 01/147 дугаар албан бичгээр “Эйкүсора” ХХК-д Татварын ерөнхий хуулийн 51 дүгээр зүйлийн 51.2-т зааснаар татварын нэхэмжлэхийг хүргүүлсэн. Татварын удирдлагын системд үүсгэсэн нэхэмжлэхүүдийг төлж барагдуулаагүй тохиолдолд Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн дагуу татварын өр хураах үйл ажиллагааг эхлүүлэхийг мэдэгджээ.

2.2.Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн “Хариу хүргүүлэх тухай” 01/343 дугаар албан бичгээр “Эйкүсора” ХХК-д “... танай байгууллагад ногдуулсан газрын төлбөрийн ногдуулалт, татварын удирдлагын системд үүсгэсэн нэхэмжлэхүүд хууль тогтоомж зөрчсөн нэхцэл байдал байхгүй байна” гэсэн хариуг өгсөн байна.

3.Нэхэмжлэгчээс нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлээ “... Манай компани Говьсүмбэр аймаг болон Дорноговь аймгийн Даланжаргалан сумын зааг дамнасан ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбай эзэмшдэг бөгөөд Говьсүмбэр аймгаас манай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн талбайд хууль бусаар газар давхцуулан олгосон асуудлаар бид шүүх болон Авлигатай тэмцэх байгууллагад хандан шийдвэрлүүлж буйн улмаас өнөөдрийг хүртэл уурхайн олборлолтын үйл ажиллагаа явуулж чадаагүй нэхцэл байдал үүссэн. ... Газрын тухай хуулийн дагуу ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайдаа газар ашиглах гэрээ байгуулаагүй, гэрчилгээ гардаж аваагүй, газрыг ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байхад Татварын газраас 357,811,475 төгрөгийн газрын төлбөр нэхэмжилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй, уурхайн эдэлбэрийн талбайд өнөөдрийг хүртэл ашиглалт хийж үйл ажиллагаа явуулаагүй тул газрын төлбөр төлөх үүрэг үүсээгүй” гэж,

4.Хариуцагч Дорноговь аймгийн Татварын газраас "... Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3.3, 45 дугаар зүйлийн 45.1-д заасны дагуу газар ашиглагч нь газрын төлбөрийг хуульд заасан хугацаанд төлөх үүргийг хүлээх ба газрыг эзэмшиж, ашиглаагүй нь төлбөр төлөх үүргээс чөлөөлөх үндэслэл болохгүй" гэж,

4.1.Хариуцагч Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргаас "... Эйкүсора" ХХК-аас ирүүлсэн 2021 оны 21/01 дүгээр хүсэлтийн дагуу тухайн компанийн ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайгаас Дорноговь аймгийн Даланжаргалан сумын нутаг дэвсгэрт хамаарах талбайн газар ашиглах эрхийг А/138 дугаар захирамжаар баталгаажуулсан.

... Хууль тогтоомжийн хүрээнд Засаг даргын шийдвэрийн холбогдох мэдээллийг сумын газрын даамал Улсын бүртгэлийн ерөнхий газарт илгээн улсын бүртгэлийн дугаар олгож, улмаар газрын төлбөрийг ногдуулж, нэхэмжлэх үүсгэсэн болно. Иймд "Эйкүсора" ХХК-ийн ашиглаж буй газарт ногдуулсан газрын төлбөрийн ногдуулалт, татварын удирдлагын системд үүсгэсэн нэхэмжлэхүүд хууль тогтоомж зэрчсөн нөхцөл байдал байхгүй" гэж маргажээ.

Анхан шатны шүүхийн шийдвэр:

5.Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 115/ШШ2025/0004 дүгээр шийдвэрийн 1 дэх заалтаар: Газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 23 дугаар зүйлийн 23.4.2, 35 дугаар зүйлийн 35.3.3, 45 дугаар зүйлийн 45.1, Газрын төлбөрийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Татварын ерөнхий хуулийн 55 дугаар зүйлийн 55.1, 55.1.1-д заасныг баримтлан нэхэмжлэгч "Эйкүсора" ХХК-ийн Дорноговь аймгийн Татварын газарт холбогдуулан гаргасан "Дорноговь аймгийн Татварын газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн "Өр хураах үйл ажиллагаа явуулах тухай" 01/147 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах" нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, 2 дахь заалтаар: Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1, 109 дүгээр зүйлийн 109.2-т заасныг баримтлан нэхэмжлэгч "Эйкүсора" ХХК-ийн Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад холбогдуулан гаргасан "Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн "Хариу хургуулэх тухай" 01/343 дугаар албан бичгийг хүчингүй болгуулах" шаардлагыг хүлээн авахаас татгалзаж, холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Давж заалдах шатны шүүхийн магадлал:

6.Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0225 дугаар магадлалаар:



Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 115/ШШ2025/0004 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн давж заалдах гомдолыг хангахгүй орхижээ.

Хяналтын журмаар гаргасан гомдол:

7. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ.

7.1. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.2-т заасан “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ноцтой зөрчил гаргасан нь шүүхийн шийдвэрт нэлөөлсөн” гэх үндэслэлээр хяналтын гомдол гаргаж байна.

7.2. Анхан шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам ноцтой зөрчсөн. Нэхэмжлэгч шүүхэд Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг дарга хэмээн нэг бие даасан субъектийг хариуцагчаар татсан. Гэтэл шүүх хуралдаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч М.Отгонбат, Н.Оюунгэрэл нар шүүх хуралдаанд орсон. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэг төлөөлөгчийг нэг л этгээд төлөөлнө. Гэтэл хариуцагчаар татагдсан нэг субъект болох Засаг даргыг хоёр этгээд төлөөлж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хууль ёсны байх зарчмыг зөрчсөн ноцтой зөрчил.

7.3. Шүүх магадлалдаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Хууль, эрх зүйн бусад акт болон үүсгэн байгуулах баримт бичгийн дагуу олгогдсон эрх хэмжээний хүрээнд байгууллагыг итгэмжлэлгүйгээр төлөөлэх этгээд, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуулийн этгээдийг төлөөлнө” гэж заасан тул хэдэн ч төлөөлөгч төлөөлж болно буюу “Засаг дарга”-ыг хувь хүн бус байгууллага гэж дүгнэсэн нь илтэд буруу дүгнэлт гэж үзэж байна.

7.4. Захиргааны шүүхийн зорилго захиргааны хууль бус үйл ажиллагаанаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах, эрх зүйн үр нэлөөтэй, өргөн хүрээтэй хамгаалалтыг баталгаажуулах, ингэснээр төрийн үйл ажиллагаа хууль ёсны байх эрх зүйт төрийн зарчмын хэрэгжилт илүү бодит байх нөхцөлийг бүрдүүлдэг. Хариуцагч Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг дарга нийтийн албан тушаалтан тул захиргааны байгууллагын төлөөлөл гэж үзэх бөгөөд түүнээс гарч буй шийдвэр, эрх зүйн акт нь төрийн байгууллагаас гарч буй захиргааны үйл ажиллагаа мөн.

7.5.Даланжаргалан сумын Засаг даргын 2021 оны А/138 дугаартай захирамжаар ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдэд газрыг эзэмшүүлж, газар эзэмшигчтэй гэрээ байгуулж, гэрчилгээ олгон газрыг зориулалтын дагуу эзэмшүүлэхийг даалгасан захирамж гарсан. Газрын тухай хууль болон Ашигт малтмалын тухай хуулийн дагуу гэрээ байгуулж, ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайдaa газар ашиглах гэрээ байгуулаагүй, гэрчилгээ гардаж аваагүй. Газрын асуудалтай холбоотой маргаан 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл хугацаанд хууль, шүүхийн байгууллагын маргаантай бүйн улмаас үйл ажиллагаа алдагдсан. Ийнхүү ашиглаагүй, үйл ажиллагаа явуулаагүй байхад Дорноговь аймгийн Татварын газраас 357,811,475 төгрөгийн газрын төлбөр нэхэмжилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна.

7.6.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “ashiigt малтмал ашиглах гэдэг нь газрын гадаргуу, түүний хэвлүй, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг”, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т “газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг ашиглана гэж хуульчилсан.

7.7.Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4-т зааснаар “Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсэгт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улс, аймгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно”, 9 дүгээр зүйлийн 1-д “газрын төлбөрийг газар эзэмших, ашиглах эрхийг улсын бүртгэлд бүртгэгдсэн буюу Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.11-д заасан дундын мэдээллийн санд улсын бүртгэлийн дугаарыг оруулсан өдрөөс эхлэн тооцно” гэж заасны дагуу манай компани уурхайн эдэлбэр талбайд өнөөдрийг хүртэл ашиглалт хийж үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд хууль тогтоомжийн дагуу газрыг ашиглаагүй, төлбөр төлөх үүрэг үүсээгүй. Иймд магадлалыг хүчингүй болгож өгнө үү гэжээ.

8.Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 231 дүгээр тогтоолоор нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдолыг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3-д заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.



## ХЯНАВАЛ:

9.Дараах үндэслэлээр шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэв.

10.Газрын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т “Газрын хэвлүй, ой, ус, хийн мандлын агаар, ургамал, амьтан, байгалийн бусад баялагийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна” гэж, Ашигт малтмалын тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглах болон хайгуулын талбай, уурхайн эдэлбэрийн орчныг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж тус тус зааснаас үзэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал олборлох үйл ажиллагаанд холбогдох газар эзэмших, ашиглах эрхийн агуулгыг нарийвчилсан зохицуулалттай хууль болох Ашигт малтмалын тухай хуулиар тодорхойлохоор байна.

11.Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “ашигт малтмал ашиглах гэж газрын гадаргуу, түүний хэвлүй, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг” гэж, 4.1.19-д “уурхайн эдэлбэр гэж уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтоцын хэсгийг” гэж, Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай (2006) хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4-т сумын Засаг даргын бүрэн эрхийг “эрх бүхий байгууллагаас олгосон ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлд заасны дагуу эдэлбэр газар олгох” гэж, Газрын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 4-т “Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа хэсэгт зохих хууль тогтоомж, гэрээний дагуу үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын газрын төлбөрийг ойр орших улсын болон орон нутгийн зэрэглэлтэй хотын бүсэд хамааруулан хоёр дахин өсгөж тооцно” гэж тус тус хуульчилсан.

12.Эдгээр зохицуулалтаас нэгтгэн дүгнэвэл ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмалыг ашиглах, тухайлбал олборлох үйл ажиллагаа явуулах “уурхайн эдэлбэр” газрын хэмжээгээр газар ашиглах эрхтэй. Харин Засаг дарга нь тухайн уурхайн эдэлбэр газрыг тусгай зөвшөөрөл эзэмшигчид олгох чиг үүргийг хэрэгжүүлэх агуулгатай байна. Улмаар газрын төлбөрийг дээрх хууль тогтоомжид заасан журмын дагуу олгогдсон “уурхайн эдэлбэр” газрын хэмжээгээр ногдуулж, төлөхөөр байна.

13. Энэ талаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн ХТ-11 дүгээр тогтоолд уурхайн талбай болон уурхайн эдэлбэрийг ялгаатай ойлголт болохыг тэмдэглэж, ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр газар олгож, гэрээг байгуулах үүрэгтэй бөгөөд уурхайн талбайн хэмжээгээр олгогдсон газрын төлбөрийг төлөхийг мэдэгдсэн нь хууль бус гэж хууль хэрэглээний хувьд дүгнэсэн нь энэ хэрэгт нэгэн адил хамааралтай.

14. Маргаан бүхий тохиолдолд хариуцагч Засаг даргын 2021 оны 08 дугаар сарын 16-ны өдрийн А/138 дугаар захирамжаар нэхэмжлэгчид түүний Даланжаргалан сум дахь MV-020419, MV-020420, MV-020421 дүгээр ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд тус бүр 202.5 га, 13.1 га, 2034 га газрыг эзэмшигүүлсэн нь дээрх уурхайн эдэлбэр газрыг олгох журamtай нийцээгүйн дээр тус захирамжид үндэслэн газрын төлбөрийг уурхайн эдэлбэрээр бус уурхайн талбайн хэмжээгээр тооцож ногдуулах үндэслэл болжээ.

15. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-д “шүүх хэргийн нөхцөл байдлыг цаашид тодруулах шаардлагатай гэж үзсэн бөгөөд нэмж тодруулах зүйлийн цар хүрээ шүүхийн шинжлэн судлах боломжкоос хэтэрсэн гэж үзвэл захиргааны байгууллагаас дахин шинэ акт гаргах хүртэл захиргааны актыг зургаан сар хүртэл хугацаагаар түдгэлэүүлэх” гэж заасан. Дээр дурдсанаар уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр газрын төлбөрийг ногдуулах учиртай ч уурхайн талбайн хэмжээгээр газар эзэмшигүүлсэн, мөн уурхайн эдэлбэр газрын хэмжээг тодорхойлоогүй байх тул энэхүү үйл ажиллагааг шүүхээс нөхөн гүйцэтгэх боломжгүй бөгөөд шүүхийн шинжлэн судлах боломжкоос хэтэрсэн байна.

16. Өөрөөр хэлбэл, нэхэмжлэгчээс 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 21/01 дүгээр албан бичгээр “ashiглалтын тусгай зөвшөөрлийдтэй талбайд уурхайн эдэлбэр газрын гэрээ байгуулах хүсэлтэй байгаа” гэж уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр гэрээ байгуулахаар хариуцагч Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргад хандсан байх учир энэ хүрээнд уурхайн эдэлбэр газар олгох үйл ажиллагааг дахин шийдвэрлэх боломжкоор хангах, улмаар түүнд үндэслэн газрын төлбөр ногдуулж, татвар хураах ажиллагааг явуулах нь хуульд нийцнэ.

17. Нөгөөтээгүүр нэхэмжлэгчээс “гэрээ байгуулаагүй, гэрчилгээ гардаж аваагүй, газрын маргаантайн улмаас газрыг ашиглаагүй” гэх агуулгаар газрын төлбөр төлөх үүрэг хүлээхгүй гэж гомдол гаргасныг хүлээн авах үндэслэлгүй. Газрын төлбөрийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4-т “Газрын төлбөрийг эзэмшил, ашиглалтад олгосон газрынх



нь нийт хэмжээгээр тооцно” гэж заасны дагуу уурхайн эдэлбэр газрыг тодорхойлж олгосон тохиолдолд бодитоор ашиглаж, үйл ажиллагаа явуулсан эсэхээс үл хамааран газрын төлбөр төлөх үүрэгтэй.

18.Иймд Дорноговь аймгийн Татварын газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/147 дугаар “Өр хураах үйл ажиллагаа явуулах тухай” шийдвэр (албан бичиг)-ийг дээр дурдсан үндэслэлийн дагуу дахин шинэ акт гаргах хүртэл зургаан сарын хугацаагаар түдгэлзүүлж шийдвэрлэв.

Шүүхийн шийдвэрийг биелүүлэх арга журмын тухайд:

19.Хариуцагч Даланжаргалан сумын Засаг даргаас энэ тогтоолын хяналт хэсгийн 11-д заасан хууль, тогтоомжийн дагуу нэхэмжлэгчийн уурхайн эдэлбэр газрын хэмжээгээр газар ашиглуулах шийдвэрийг дахин гаргаж, Улсын бүртгэлийн цахим санд илгээх шаардлагатай. Ингэхдээ нэхэмжлэгчийн зүгээс уурхайн эдэлбэр газрын хэмжээ, газрын эргэлтийн цэгийг баталгаажуулахад шаардлагатай мэдээллийг хариуцагч Засаг даргад шинэчлэн хүргүүлэх ёстай.

20.Үүнийг үндэслэн хариуцагч Дорноговь аймгийн Татварын газар Улсын бүртгэлийн цахим санд шинээр бүртгэгдсэн газрын хэмжээгээр газрын төлбөрийг ногдуулах арга хэмжээг авч энэ шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.2-т заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Дорноговь аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 115/ШШ2025/0004 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0225 дугаар магадлалын тогтоох хэсгийг “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.3.11-д заасныг баримтлан Дорноговь аймгийн Татварын газрын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн 01/147 дугаар “Өр хураах үйл ажиллагаа явуулах тухай” шийдвэр (албан бичиг)-ийг дахин шинэ акт гаргах хүртэл 6 сарын хугацаагаар түдгэлзүүлсүгэй. 2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 107 дугаар зүйлийн 107.6-д зааснаар шүүхээс тогтоосон хугацаанд захиргааны байгууллага шинэ акт гаргаагүй бол уг маргаан бүхий акт хүчингүй болохыг дурдсугай” гэж, 2, 3, 4 дэх заалтын дугаарыг 3, 4, 5 болгон өөрчилж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхисугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар нэхэмжлэгчээс улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 төгрөгийг улсын орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ**

**Х.БАТСҮРЭН**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**Г.БАНЗРАГЧ**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

**Ц.ЦОГТ**



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0063

Улаанбаатар  
хот

“МИГ даатгал” ХХК-ийн гомдолтой,  
Санхүүгийн зохицуулах хорооны  
улсын байцаагч М.Тамирт холбогдох  
захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн  
шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:	М.Батсуурь
Танхимын тэргүүн:	Д.Мөнхтуяа
Шүүгчид:	П.Соёл-Эрдэнэ
	Ц.Цогт
Илтгэгч шүүгч:	Г.Банзрагч
Нарийн бичгийн дарга:	Б.Зэнээмэдрээ

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны  
12 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/1019 дүгээр шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05  
дугаар сарын 08-ны өдрийн 221/МА2025/0312 дугаар магадлалтай,

Шүүх хуралдаанд оролцогчид: Гомдол гаргагчийн итгэмжлэгдсэн  
төлөөлөлөгч Э.Чинбаатар, өмгөөлөгч Н.Энхчимэг, хариуцагчийн  
итгэмжлэгдсэн төлөөлөлөгч Б.Ням-Очир нарыг оролцуулж,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн  
хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 001/ШХТ2025/0264  
дүгээр хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, Захиргааны хэрэг шүүхэд хянан  
шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3-т заасан үндэслэл  
байгаа эсэхийг гомдол гаргагчийн төлөөлөгчийн хяналтын журмаар  
гаргасан гомдлоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Гомдлын шаардлага:

“МИГ даатгал” ХХК-аас Санхүүгийн зохицуулах хорооны улсын  
байцаагч М.Тамирт холбогдуулан “Санхүүгийн зохицуулах хорооны улсын  
байцаагч М.Тамирын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 0014100  
дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгуулах” гомдлын шаардлага  
гаргажээ.

2.Хэргийн нөхцөл байдал:

2.1.“МИГ даатгал” ХХК, Б.Золжаргал нар 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдөр 23201/908 дугаар “Тээврийн хэрэгслийн төрөлжсөн даатгалын гэрээ”-г байгуулсан байх бөгөөд талуудын хооронд даатгалын нөхөн төлбөртэй холбоотой асуудал үүсэж, даатгуулагч Б.Золжаргалаас “МИГ даатгал” ХХК, Санхүүгийн зохицуулах хороонд тус тус хандсан байна.

2.2.“МИГ даатгал” ХХК-ийн 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 01/12-790, 2024 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 01/11-1036 дугаар албан бичгүүдээр даатгуулагч Б.Золжаргал болон Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргад нөхөн төлбөр олгохоос татгалзаж шийдвэрлэсэн талаар мэдэгдсэн.

2.3.Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар “... даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгох асуудлыг шийдвэрлэж, шийдвэрийн талаарх мэдээллийг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус Хороонд болон даатгуулагчид мэдэгдэн үү” гэсэн албан бичгийг “МИГ даатгал” ХХК-д хүргүүлсэн.

2.4.Дээрх албан бичгийн хариуд “МИГ даатгал” ХХК-ас 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 01/12-1148 дугаар албан бичгээр “... нөхөн төлбөр олгохоос татгалзаж шийдвэрлэсэн шийдвэрээ хэвээр үлдээж байгаа” талаар Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргад мэдэгджээ.

2.5.Б.Золжаргалаас 2024 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр Санхүүгийн зохицуулах хороонд гаргасан гомдлын дагуу хариуцагч улсын байцаачаас зөрчлийн хэрэг нээж, 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 0014100 дугаар шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д зааснаар “эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй” зөрчил гаргасан гэж үзэн “МИГ даатгал” ХХК-д 5,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулжээ.

3.Гомдол гаргагчаас дараах үндэслэлээр маргаж байна. Үүнд:

“... Улсын байцааг нь даатгуулагчтай байгуулсан гэрээний эрх зүйн харилцаанд оролцох, нөхөн төлбөр олгох даалгавар өгөх, шүүхийн эрхийг хэрэгжүүлэх эрхгүй. Санхүүгийн зохицуулах хороо нь иргэний эрх зүйн өмчийн харилцааны маргаанд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу урьдчилан шийдвэрлэх журмыг хэрэгжүүлэх бөгөөд энэ нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасан урьдчилан шийдвэрлэх журмыг хэрэгжүүлж буй хэлбэр юм. Нөхөн төлбөр



олгох эсэх үндэслэлийн хэмжээнд зөвхөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт өгдөг. Санхүүгийн зохицуулах хорооноос ирүүлсэн бичиг нь Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан даалгаврын шинж, хэлбэрийг агуулаагүй, албадлагын арга хэмжээ авах шийдвэр биш гэж үзэж байна. Даатгуулагч салхины шилний зураас хаана үүссэн, юунаас үүссэн гэдгийг даатгагчид нотолж өгөгүй, мөн тухайн эвдрэлд өмнөх осолтой холбоотой шинж агуулсан баримтууд байсан учраас даатгагчийн зүгээс нөхөн төлбөр олгох боломжгүй гэж үзэж татгалзсан. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны 2024 оны 3/2646 дугаар албан бичиг нь мэдэгдлийн агуулгатай бөгөөд хариуг тогтоосон хугацаанд нь албан бичгээр хүргүүлсэн байхад эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй гэх үндэслэлээр шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй ...” гэжээ.

4.Хариуцагчаас гомдлын шаардлагыг эс зөвшөөрч “... Нөхөн төлбөрийг олгохоос татгалзаж шийдвэрлэсэн нь үндэслэлгүй, тухайн тохиолдол нь зам тээврийн осолд хамааралгүй, зөвхөн тээврийн хэрэгслийн салхины шилэнд учирсан хохирол байдаг. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасныг үндэслэн даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олго асуудлыг урьдчилан шийдвэрлэж, хэрхэн шийдвэрлэсэн талаар мэдэгдэхийг даатгуулагчид үүрэг болгосон. “МИГ даатгал” ХХК нь Санхүүгийн зохицуулах хорооны шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд хандаж шийдвэрлүүлээгүй тул Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасныг үндэслэл болгон даатгуулагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, хохирлыг барагдуулах талаар хуулийн хүрээнд шаардлагатай арга хэмжээг авсан. Зөрчлийн тухай хуульд зааснаар эрх бүхий албан тушаалтны зүгээс зөрчилд шийтгэл оногдуулсан нь үндэслэлтэй, улсын байцаагч эрх хэмжээгээ хэтрүүлээгүй. Гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчөөгүй ... ” гэх зэргээр маргасан.

5.Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/1019 дүгээр шийдвэрээр “Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18, Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасныг тус тус үндэслэн “МИГ даатгал” ХХК-аас гаргасан гомдлын шаардлагыг бүхэлд нь хангаж, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч М.Тамирын 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 0014100 дугаар шийтгэлийн хуудсыг хүчингүй болгож” шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг хийсэн байна. Үүнд:

5.1.“... Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичиг нь нэгдүгээрт, Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан “албадлагын арга хэмжээний хүрээнд өгч буй даалгавар” биш, хоёрдугаарт, тухайн

албан бичгээр даатгуулагч Б.Золжаргалд даатгалын нөхөн төлбөр олгохыг компаниас шууд шаардсан нь маргаанд оролцогч талуудын хувьд шүүхэд хандах эрхэд халдсан, тэдний эрх ашгаа хамгаалж маргах эрхийг хөндсөн хууль бус мэдэгдэл гэж үзнэ.

5.2. Түүнчлэн маргааны оролцогч талууд Санхүүгийн зохицуулах хорооны урьдчилан шийдвэрлээд гаргасан шийдвэрийг эс зөвшөөрч шүүхэд гомдол гаргах эрх нь нээлттэй төдийгүй даатгалын нөхөн төлбөрийг хариуцагчийн шаардсанаар шууд төлөх үүрэг "МИГ даатгал" ХХК-д үүсэхгүй, гэрээнд энэ талаар талууд нарийвчлан зохицуулсан. Иймд Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй гэж үзэх хууль зүйн үндэслэлгүй, тус компани нь Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д заасан эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй зөрчил гаргаагүй байна ...

5.3. Хариуцагч өөрт олгосон эрх хэмжээг зорилгодоо нийцээгүй байдлаар ашигласны улмаас түүний гаргасан шийтгэлийн хуудас хууль зөрчсөн үндэслэлгүй болох нь тогтоогдож байх тул шийтгэлийн хуудсыг бүхэлд нь хүчингүй болгож, гомдлын шаардлагыг хангаж шийдвэрлэх нь зүйтэй ..." гэх зэрэгээр дүгнэжээ.

6. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 221/МА2025/0312 дугаар магадлалаар "Анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18, 11.13 дугаар зүйлийн 15.22 дахь заалтыг тус тус баримтлан гомдол гаргагч "МИГ даатгал" ХХК-ийн гаргасан гомдлын шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож" шийдвэрлэхдээ дараах дүгнэлтийг өгсөн байна. Үнд:

6.1. "... Хариуцагчаас гомдол гаргагч "МИГ даатгал" ХХК-д даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олгох асуудлыг шийдвэрлэх талаар 2024 оны 3/2646 дугаар албан бичиг буюу даалгавар хүргүүлсэн боловч Санхүүгийн зохицуулах хорооны дээрх шийдвэрийг биелүүлээгүй, мөн шийдвэрийг эс зөвшөөрч гомдол гаргаагүй байх тул маргаан бүхий улсын байцаагчийн шийтгэлийн хуудас нь зорилгодоо нийцсэн, бодит нөхцөлд тохирсон, шийдвэр нь үндэслэл бүхий байх зарчмыг хангасан, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаар тогтоогдсон зөрчилд шийтгэл оногдуулсан нь хуульд нийцсэн, үндэслэл бүхий байна.

6.2. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 18 дугаар зүйлийн 18.3-т зааснаас үзвэл Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны дарга нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд 2024 оны 3/2646 дугаар албан бичгээр "МИГ даатгал" ХХК-д даалгавар хүргүүлсэн. Өөрөөр хэлбэл, даалгаврыг биелүүлээгүй үндэслэлээр зөрчилд тооцож шийтгэл оногдуулсан нь Зөрчлийн тухай



хуулийн 3.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасантай нийцсэн. Мөн тухайн даалгаврыг эс зөвшөөрөл гомдол гаргах эрхийг тусгасан байх бөгөөд “МИГ даатгал” ХХК нь гомдол гаргаагүй атлаа ийнхүү шүүхэд маргасныг хүлээн авах үндэслэлгүй ...” гэжээ.

7. Гомдол гаргагчийн төлөөлөгч С.Ануужин хяналтын журмаар гаргасан гомдолдоо:

7.1. “... Давж заалдах шатны шүүх хэргийн үйл баримтыг бүрэн зөв үнэлж чадаагүй, хуулийг буруу тайлбарлан Улсын дээд шүүхийн тогтоолоос өөрөөр хэрэглэсэн ... Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3-т заасан “Ажлын албаны дарга нь Хорооны ерөнхий менежер байна” гэдэг агуулгыг Санхүүгийн зохицуулах хороог төлөөлөх, мөн хуулиар тусгайлан олгосон эрх, үргийг хэрэгжүүлэх эрхтэй гэж тайлбарлаж буй нь үндэслэлгүй. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан зохицуулалтаар Санхүүгийн зохицуулах хороо нь хамтын удирдлагатай байгууллага буюу гишүүдийн тогтоолоор шийдвэрээ гаргадаг. Энэхүү эрх хэмжээгээ менежер буюу ажлын албаны даргад шилжүүлэх эрхгүй болохыг хуулиар тодорхойлсон.

7.2. Мөн Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон зөвшөөрөл эзэмшигч, үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ” гэж заасны дагуу даатгач болон даатгуулагч нарын хооронд үүссэн нөхөн төлбөрийн маргаанд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.3-т заасны дагуу шүүхийн өмнөх шатны урьдчилан шийдвэрлэх журмыг хангаж буй хэлбэр бөгөөд нөхөн төлбөр олгох, эс олгох гэсэн 2 үндэслэлийн хэмжээнд зөвхөн мэргэжлийн байгууллагын дүгнэлт өгдөг ба гэрээний талууд иргэний хэргийн шүүхэд нэхэмжлэл гаргаж маргаанаа шийдвэрлүүлэх боломжтой талаар албан бичгээр зөвлөмж өгдөг тул Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан даалгаврын шинж, хэлбэрийг агуулаагүй, албадлагын арга хэмжээ авах шийдвэр гараагүй. Энэ талаар Улсын дээд шүүхийн 2016 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 440 дүгээр тогтоолоор даатгалын тохиолдлын хувьд даалгавар даалгах эрхгүй болохыг хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах хүрээнд тайлбарлаж хэрэглэсэн байтал энэ талаар тогтоолоос өөрөөр, хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн.

7.3. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичиг нь мэдэгдлийн агуулгатай байх бөгөөд “хэрхэн шийдсэнээ тогтоосон хугацаанд мэдэгд” гэснийг биелүүлсэн атал ийм үндэслэлээр зөрчлийн хэрэг үүсгэн шийтгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй. Даалгавар нь хууль зүйн агуулгаар хоёргүй

утгаар хэрэглэгдэх төрийн захиргааны байгууллага хуулиар тогтоон олгосон эрх хэмжээнийхээ хүрээнд эрх бүхий этгээдийн шийдвэр бүхий албан ёсны заавар чиглэл юм. Гэтэл дээрх албан бичгийг албан даалгавар гэж дүгнэсэн нь буруу. Санхүүгийн зохицуулах хорооны ажлын албаны даргад тус байгууллагыг төлөөлөх бүрэн эрх олгогдоогүй, уг бичиг нь хэрхэн шийдсэнээ мэдэгд гэсэн агуулгатай мэдэгдэл байна. Хариуцагчаа “МИГ даатгал” ХХК-д хандаж нөхөн төлбөр олгохоос үндэслэлгүй татгалзсан болохыг тогтоож даатгуулагч Б.Золжаргалд нөхөн төлбөрийг олгож, хариу мэдэгдэхийг үүрэг болгосон нь нэхэмжлэгчид эрх зүйн үр дагавар үүсгэсэн, тодорхой нэг тохиолдлыг зохицуулсан захирамжилсан шийдвэр байх тул уг албан бичиг нь захиргааны актын шинжийг бүрэн агуулсан. Энэ тохиолдолд захиргааны байгууллага нь өөрийн бүрэн эрхэд хамааралгүй гомдлыг буюу иргэний хэргийн шүүхээр шийдвэрлэх эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэж, өөрт олгогдсон эрх хэмжээгээ хэтрүүлсэн.

7.4. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, мөн хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан зохицуулалтаас үзэхэд Санхүүгийн зохицуулах хороо нь тусгай зөвшөөрөл эзэмшигч “МИГ даатгал” ХХК, даатгуулагч Б.Золжаргал нарын хооронд үссэн бүх маргааныг шийдвэрлэхгүй, зөвхөн өөрийн эрх хэмжээ, чиг үүрэгт хамаарах асуудлаар гарсан маргааныг өөрийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэх ёстой. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд тавих Санхүүгийн зохицуулах хорооны хяналт, чиг үүрэг, оролцооны хүрээг тодорхойлсон бөгөөд даатгагч, даатгуулагчийн хооронд үссэн, даатгалын гэрээний үүргийн гүйцэтгэл, хохирол, төлбөртэй холбоотой асуудлаарх маргааныг шийдвэрлэх, хохирол төлбөрийг гэрээний аль нэг талд хариуцуулахаар тогтоох, хэн аль нь хохирсон талаар дүгнэлт гаргах эрхийг Санхүүгийн зохицуулах хороонд олгогүй байх тул маргаан бүхий захиргааны актаар нэхэмжлэгчид “... төлбөр төлж, хариу мэдэгдэх”-ийг даалгасныг захиргааны байгууллагын өөрийн “эрх хэмжээний хүрээнд” гэж үзэх боломжгүй. Захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын үйл ажиллагааг хянахдаа юуны түрүүнд захиргааны байгууллага өөрт нь харьялан шийдвэрлэх өргөдөл, гомдлыг шийдсэн эсэх, тухайн асуудлаар шийдвэр гаргах эрх хуулиар олгогдсон эсэхийг нягтлан шалгах ёстой ...

7.5. Хэдийгээр Санхүүгийн зохицуулах хороо иргэдийн өргөдөл, гомдлыг хянан шалгах, тухайлбал даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулсан эсэхийг шалгаж тогтоох, захиргааны шийтгэл оногдуулах, тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааг түр зогсоох эрхтэй боловч “нөхөн төлбөр олгохыг даалгах” шийдвэр гаргах эрхгүй. Даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т зааснаар даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар



зохицуулах, мөн хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасан зохицуулалтаас үзэхэд даатгалын гэрээний талуудын хооронд үүссэн маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэх юм. Мөн улсын байцаагчийн бие даан гаргасан шийдвэр нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг зөрчин, захиргааны байгууллагыг төлөөлж эрх бүхий этгээдүүдийн өмнөөс шийдвэр гаргасан үйлдэл нь хууль бус бөгөөд үүрэг болгосон албан бичиг нь тогтоол хэлбэрээр биш тул эрх зүйн үр дагавар үүсгэх үндэслэлгүй. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж өгнө үү” гэжээ.

8.Хариуцагч тал “гомдол гаргагчийн төлөөлөгчийн гомдол үндэслэлгүй, давж заалдах шатны шүүхийн магадлал хууль ёсны тул хэвээр үлдээж өгнө үү” гэсэн агуулгатай тайлбарыг өгөв.

9.Хяналтын шатны шүүх гомдол гаргагчийн төлөөлөгчийн гомдлыг “хуулийг Улсын дээд шүүхийн тогтоол, тайлбараас өөрөөр хэрэглэсэн” үндэслэл байгаа эсэхийг хянан хэлэлцэхээр хүлээн авсан болно.

#### ХЯНАВАЛ:

10.Гомдол гаргагчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангах үндэслэлтэй.

11.Энэхүү хэргийн тухайд, хяналтын шатны шүүхээс Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд Санхүүгийн зохицуулах хорооноос гаргах шийдвэрийн цар хүрээ, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасан Санхүүгийн зохицуулах хорооны эрх хэмжээг маргааны үйл баримтад холбогдуулан хэрхэн тайлбарлан хэрэглэх талаар; Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасны дагуу даатгач, даатгуулагчийн хооронд байгуулагдсан даатгалын гэрээний дагуу нөхөн төлбөр олгох эсэхтэй холбоотой харилцаанд (талуудын хооронд үүссэн маргаанд) Санхүүгийн зохицуулах хорооноос даатгагчид “нөхөн төлбөр олгох”-ыг даалгах буюу “даалгавар өгөх” эрхтэй эсэх, мөн тухайн асуудлаар шийдвэр гаргах боломжтой эсэхэд хууль зүйн дүгнэлт өгөх нь зүйтэй байна.

12.Нэг.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д заасан зохицуулалтуудын талаар:

12.1.Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д “Хороо өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд болон зөвшөөрөл эзэмшигч,

үйлчлүүлэгчийн хооронд гарсан маргааныг урьдчилан шийдвэрлэнэ” гэж, Даатгалын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлнэ”, 82 дугаар зүйлийн 82.1-д “Аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд шийдвэрийг эс зөвшөөрвэл уг шийдвэрийг хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдаж болно” гэж тус тус заасны дагуу Санхүүгийн зохицуулах хороо нь даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрх бүхий захиргааны байгууллагын хувьд даатгагч, даатгуулагчийн хооронд гарсан аливаа маргааныг, түүний дотор даатгалын нөхөн төлбөр олгох эсэхтэй холбоотой маргааныг захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх эрхийг дээрх хуулийн заалтуудаар олгосон гэж үзнэ.

12.2.Гэхдээ Санхүүгийн зохицуулах хорооны болон санхүүгийн зах зээлийн харилцаанд оролцогчдын эрх зүйн байдал, зохицуулах чиг үүргийн онцлогоос хамаарч даатгагч, даатгуулагчийн хооронд үүссэн гэрээний эрх зүйн маргааныг урьдчилан шийдвэрлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааг хянах, зохицуулах чиг үүргийн хүрээнд өөрийн эрх хэмжээний асуудлаар захиргааны акт гаргах замаар дээрх эрх хэмжээг ялгамжтай хэрэгжүүлэхээр байна.

12.3.Тодруулбал, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д зааснаар “Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага мөн”. Өөрөөр хэлбэл, уг байгууллага нь санхүүгийн зах зээлийн харилцаанд оролцогчдын үйл ажиллагааг нийтийн эрх зүйн үүднээс хянан зохицуулах буюу тухайн зах зээлд үйлчилгээ үзүүлж буй этгээдүүд нь холбогдох хууль, журмын дагуу үйл ажиллагаа явуулж буй эсэх, хууль зөрчсөний улмаас хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг зөрчсөн эсэхийг шалгаж тогтоох, зөрчигдсөн эрхийг сэргээн хамгаалах чиг үүрэгтэй захиргааны байгууллага юм.

12.4.Хорооны энэхүү чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль (нийтийн эрх зүйн хэм хэмжээ)-аас гадна Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хадгаламж, зээлийн хоршооны тухай хууль, Даатгалын тухай хууль зэрэг хууль тогтоомжоор зохицуулсан. Эдгээр хуулиуд нь нэг талаас нийтийн захиргааг хэрэгжүүлэгч Хороо, негөө талаас санхүүгийн зах зээлд үйлчилгээ үзүүлэгч этгээдийн хооронд үүссэн нийтийн эрх зүйн (захирах-захиргадах) харилцааг зохицуулсан хэм хэмжээнээс гадна санхүүгийн зах зээлд оролцогчдын буюу санхүүгийн үйлчилгээ үзүүлэгч болон



үйлчлүүлэгч/хөрөнгө оруулагчдын хоорондын хувийн эрх зүйн (харилцан зөвшилцөх) харилцааг зохицуулсан “холимог шинжтэй” гэж болохуйц хэм хэмжээг агуулсан хууль тогтоомжоор зохицуулсан байдгаараа онцлог шинжтэй.

12.5. Тухайлбал, Даатгалын тухай хуулийн зорилт нь уг хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1-д зааснаар “даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоож, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, даатгалын үйл ажиллагааг эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах” гэсэн нийтийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдэх боловч, мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.2-т зааснаар “Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсэх гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулах”-аас гадна уг хууль дахь даатгалын нөхөн төлбөр, даатгагч, даатгуулагчийн эрх, үүргийг зохицуулсан зүйл, заалт зэрэг нь хувийн эрх зүйн харилцааг зохицуулсан шинжтэй байна.

12.6. Иймд Хороо нь Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д заасны дагуу урьдчилан шийдвэрлэх чиг үүргээ хэрэгжүүлэхдээ тухайн маргаан нь нийтийн эрх зүйн шинжтэй ю, эсхүл хувийн эрх зүйн хэм хэмжээнээс үүдэлтэй байна уу гэдгийг харгалзан үзэх шаардлагатай, үүнээс хамаарч урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэсэн Хорооны шийдвэрийн эрх зүйн үр дагавар нь ялгаатай байхаар байна.

12.7. Тодруулбал, Даатгалын тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.1-д зааснаар Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвэл шүүхэд давж заалдах зохицуулалт нь тухайн маргааны үндсэн шинжээс хамаарч, маргааны аль тал нь аль шүүхэд хандах боломжтой нь тодорхойлогдох буюу Хороо болон тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хоорондын захираг-захирагдах харилцаанд үндэслэн үүссэн маргааныг (тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох, түдгэлзүүлэх зэрэг албадлагын арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах гэх мэт) урьдчилан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлэсэн Хорооны шийдвэрийг эс зөвшөөрвэл тусгай зөвшөөрөл эзэмшигч захиргааны хэргийн шүүхэд, харин тусгай зөвшөөрөл эзэмшигч болон үйлчлүүлэгчийн хороонд байгуулагдсан (иргэний) гэрээнээс үүдэлтэй маргаанд Хороо нь хөндлөнгийн буюу “зохицуулагч”-ийн үүднээс урьдчилсан шийдвэр гаргасан бөгөөд даатгуулагч уг шийдвэрийг эс зөвшөөрвэл иргэний хэргийн шүүхэд хандах эрхтэй гэж ойлгоно.

12.8. Өөрөөр хэлбэл, “даатгалын нөхөн төлбөр олгохыг даалгах” агуулгатай Хорооноос гарсан шийдвэрийг даатгагч зөвшөөрвэл даатгуулагчид нөхөн төлбөрийг олгох, харин зөвшөөрөөгүй тохиолдолд

даатгуулагч шүүхийн журмаар маргах боломжтой, түүнчлэн Хорооноос “нөхөн төлбөр олгох үндэслэлгүй” талаар шийдвэр гарвал даатгуулагч шүүхэд хандах эрхтэй.

12.9. Энэ тохиолдолд, “МИГ даатгал” ХХК нь иргэн Б.Золжаргалтай “Тээврийн хэрэгслийн төрөлжсөн даатгалын гэрээ” байгуулсан, уг гэрээний дагуу даатгагч нь даатгуулагчид нөхөн төлбөр олгохоос татгалзсантай холбоотойгоор маргаан үүсэж, улмаар Хорооны ажлын албаны 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 3/2646 дугаар албан бичгээр “МИГ даатгал” ХХК-д хандан “... даатгалын гэрээнд заасан эрсдэлийн улмаас даатгуулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг олго асуудлыг шийдвэрлэж, шийдвэрийн талаарх мэдээллийг 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор тус Хороонд болон даатгуулагчид мэдэгдэх”-ийг үүрэг болгосон, үүний хариуд “МИГ даатгал” ХХК-аас “нөхөн төлбөр олгохоос татгалзаж шийдвэрлэсэн шийдвэрээ хэвээр үлдээж байгаа” талаар Хороонд мэдэгдсэн агуулгаас үзвэл, даатгагч, даатгуулагчийн хооронд иргэний буюу даатгалын гэрээнээс үүдэлтэй маргаан үүссэн. “МИГ даатгал” ХХК нь даатгуулагч иргэн Б.Золжаргалд нөхөн төлбөр олгохоос татгалзсан, тухайн иргэн уг асуудлаар иргэний хэргийн шүүхэд хандсан байх тул энэ маргааны хувьд Хорооны ажлын албаны 2024 оны 3/2646 дугаар албан бичгээр захиргааны журмаар урьдчилан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болсон, шүүхийн журмаар маргаан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилсэн гэж үзнэ.

12.10. Иймд “дээрх шийдвэрийг даатгагч эс зөвшөөрсөн бол захиргааны хэргийн шүүхэд хандах ёстой байсан, гэтэл хандаагүй тул хүчин төгөлдөр болсон” гэх агуулгатай давж заалдаш шатны шүүхийн дүгнэлт буруу, дээр дурдсанчлан нөхөн төлбөр олгох эсэхтэй холбоотой, талуудын хооронд байгуулагдсан гэрээнээс үүдэлтэй маргаанд урьдчилан шийдвэрлэх ажиллагаа, түүний үр дагаврыг буруу тайлбарлан хэрэглэсэн, энэ талаарх гомдол гаргагчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдол үндэслэлтэй.

13. Хоёр Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10, Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д заасан зохицуулалтын талаар:

13.1. Даатгуулагч Б.Золжаргалаас Санхүүгийн зохицуулах хороонд гаргасан гомдлын дагуу хариуцагч улсын байцаагчаас зөрчлийн хэрэг нээж, маргаан бүхий шийтгэлийн хуудсаар Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д зааснаар “эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй” гэх зөрчил гаргасан гэж үзэн “МИГ даатгал” ХХК-д 5,000,000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулсан, хариуцагч уг шийдвэрийн үндэслэлээ “Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан эрх хэмжээний хүрээнд гаргасан” гэж тайлбарлажээ.



13.2. Даатгалын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-д “Зохицуулах хороо энэ хуулийн 67.1-д заасан үндэслэлээр дараах төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ.” гээд 68.1.4-т “энэ хуулийн 73 дугаар зүйлд заасны дагуу даалгавар өгөх” гэж, 73 дугаар зүйлийн 73.1.10-т “даатгуулагч болон хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” гэж тус тус заасан, мөн хуулийн 73.1.1-73.1.9-д заасан зөрчлийн шинж байдлыг авч үзвэл, 73 дугаар зүйлийн 73.1-д заасан даалгавар нь даатгагч зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулсан, эсхүл хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан зэрэг хуулийг “ноцтой” зөрчсөн тохиолдолд авах “албадлагын арга хэмжээ” байна. Иймд хуулийн системчлэл, логикоор нь 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан “шаардлагатай гэж үзсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх” үндэслэлийг тайлбарлавал, даатгагчийн зүгээс 73.1.1-73.1.9-д заасантай дүйцэхүйц хэмжээний хуулийн зөрчил гаргаснаас даатгуулагчийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд авах албадлагын арга хэмжээ гэж үзэхээр байна.

13.3. Даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5-д зааснаар даатгагч нь хуульд заасан үндэслэлээр нөхөн төлбөрийг бүрэн буюу түүний зарим хэсгийг олгооос татгалзах эрхтэй, энэхүү эрхийнхээ дагуу “МИГ даатгал” ХХК нь даатгалын нөхөн төлбөрийг олгооос татгалзсан талаараа Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдсэн байхад үүнийг “Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д заасан зөрчил гаргасан” гэж үзсэн нь үндэслэлгүй, хариуцагч нь хуулийн дээрх заалтуудыг буруу хэрэгжүүлсэн гэж үзнэ.

13.4. Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18-д “даатгагч ... эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй” бол зөрчилд тооцохоор заасан, даатгалын гэрээний үүргийн гүйцэтгэлтэй холбоотой үүссэн маргааныг иргэний хэргийн шүүх шийдвэрлэхээр хуульд тусгайлан заасан байхад “захиргааны журмаар албадан биелүүлүүлэх” агуулгаар “зөрчил”-д тооцож, албадлагын арга хэмжээ авсан нь дээр дурдсан хуулийн зорилго, системчлэлд нийцэхгүй, энэ талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй байна.

14. Нэгтгэн дүгнэвэл, Хорооны ажлын албанаас 2024 оны 3/2646 дугаар албан бичгээр даатгагч “МИГ даатгал” ХХК-д хандан “нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэх” талаар үүрэг хүлээлгэснийг Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10-т заасан даалгавар буюу албадлагын арга хэмжээ гэж үзэхгүй ч, зохицуулах байгууллагын хувьд ийнхүү үүрэг хүлээлгэснийг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд гарсан шийдвэр гэж үзэх бөгөөд хууль бус гэх үндэслэлгүй. Энэ утгаар анхан шатны шүүхийн “... Хорооны 2024 оны 3/2646 дугаар албан бичгээр иргэн Б.Золжаргалд даатгалын нөхөн төлбөр олгохыг компаниас

шууд шаардсан нь ... хууль бус мэдэгдэл ..." гэсэн дүгнэлтийг запруулах нь зүйтэй.

15.Иймд шүүх бүрэлдэхүүн гомдол гаргагчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан "давж заалдаш шатны шүүх Зөрчлийн тухай хуулийн 11.13 дугаар зүйлийн 15.18, Даатгалын тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдо заалтуудыг буруу тайлбарлан хэрэглэсэн" гэх агуулгатай гомдлыг хангаж, давж заалдаш шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээхээр тогтов.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.3-т заасныг удирдлага болгон

ТОГТООХ нь:

1.Захиргааны хэргийн давж заалдаш шатны шүүхийн 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 221/МА2025/0312 дугаар магадлалыг хүчингүй болгож, нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 128/ШШ2024/1019 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, гомдол гаргагчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангасугай.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т зааснаар гомдол гаргагч "МИГ даатгал" ХХК-аас улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**М.БАТСУУРЬ**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

**Ц.ЦОГТ**

**Г.БАНЗРАГЧ**



## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0064

Улаанбаатар  
хот

Д.Сайнбилэгийн нэхэмжлэлтэй,  
Баянзүрх дүүргийн Засаг даргад  
холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:  
Шүүгчид: Танхимын тэргүүн

П.Соёл-Эрдэнэ  
Д.Мөнхтуяа

М.Батсуурь  
Ц.Цогт

Илтгэгч шүүгч:  
Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга: Б.Энхжаргал

Х.Батсүрэн

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 128/ШШ2024/1041 дүгээр шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 221/МА2025/0196 дугаар магадлал,

Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 001/ШХТ2025/0265 дугаар хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Отгонбаярыг оролцуулан нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдоор хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэхэмжлэлийн шаардлага:

1.Д.Сайнбилэгээс “Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Газар зээмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” А/422 дугаар захирамжийн Д.Сайнбилэгт холбогдох хэсгийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

Хэргийн нөхцөл байдал:

2.Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/422 дугаар захирамжаар: Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 40 дүгээр зүйлийн 40.1.1, 40.1.5, 40.1.6, 40.2, 49 дүгээр зүйлийн 49.3.1, 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт газар эзэмших эрх олгогдсон газраа хүндэтгэн үзэх шалтгаангүй зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй, газрын гэрээ, гэрчилгээгээ аваагүй, газрын төлбөрөө хугацаанд нь төлөөгүй хавсралтад дурдсан иргэн (хавсралтын 57 дугаарт Д.Сайнбилэг), аж ахуйн нэгж, байгууллагын газар эзэмших эрхийг хүчингүй болгожээ.

3.Нэхэмжлэгчээс "... 2010 оноос газар эзэмшиж эхэлснээс хойш Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасны дагуу газар эзэмших үүргээ хэрэгжүүлсэн, газар эзэмших гэрээний дагуу улирал тутам газрын төлбөрийг төлөхөөр тохиролцсон ба ebarimt цахим системээр эхний улиралд багтаан тухайн жилийн газрын төлбөрөө бөөнд нь төлсөн байхад газрын төлбөрөө төлөөгүй гэж үзсэн нь үндэслэлгүй, хариуцагч газар эзэмших эрхийг хүчингүй болгоходо газрыг зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй нь "хүндэтгэн үзэх шалтгаан"-тай байсан эсэхийг тодруулаагүй, шийдвэр гаргах ажиллагаанд хамаарах бодит нэхцэл байдлыг тогтоох, нотлох баримт цуглуулах, захиргааны акт гаргахын өмнө эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдж болзошгүй этгээдэд захиргааны шийдвэр гаргахад ач холбогдол бүхий нэхцэл байдлын талаар тайлбар, санал гаргах боломж олгох байдлаар сонсох ажиллагаа явуулаагүй, энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 24-27 дугаар зүйлд заасан шийдвэр гаргах ажиллагааны журам зөрчсөн, сөрөг нелөөлөл бүхий захиргааны актыг гаргахдаа бодит нэхцэл байдлыг тогтоогоогүй, гомдол гаргагчийн оролцоог хангаагүй тул захиргааны байгууллагын үйл ажиллагаа нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д заасан зарчмыг зөрчсөн, мөн Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.8 дахь хэсэг нь зөвхөн нэхэмжлэгчид хамаарахгүй бөгөөд гэрээний хэрэгжилтийг хянан үзэж, алдаа зөрчлийг тухай бүр засуулах, урьдчилан сануулах үүрэг захиргаанд мөн хамаарна, захиргаа зөрчлийг арилгуулах боломжит арга хэмжээ авсаар байхад газар эзэмшигч үүргээ биелүүлээгүй тохиолдолд газар эзэмших эрхийг хүчингүй болгох арга хэмжээ авах нь захиргааны эрх, тус газрын алба буюу захиргааны байгууллага хуулиар хүлээлгэсэн үүргээ биелүүлэхгүйгээр гомдол гаргагчийг буруутгаж газар эзэмших эрхийг хүчингүй болгосон нь үндэслэлгүй, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2-т зааснаар хариуцагч эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдж буй этгээдэд мэдэгдэх үүрэгтэй, ингэснээр дээд шатны байгууллага, эсхүл шүүхэд хандах замаар эрхээ сэргээлгэх



агуулгатай, гэвч нэхэмжлэгч 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Газрын албандаа очиж мэдсэн, захираганы байгууллагаас актыг мэдэгдээгүй, хэзээ, хэрхэн, яаж мэдэгдсэн нь тодорхойгүй, Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6-д заасан зөрчлийг гаргаагүй ...” гэж нэхэмжлэлийн үндэслэлээ тодорхойлон маргажээ.

3.1.Хариуцагчаас “... Баянзүрх дүүргийн Засаг даргын 2010 оны 197 дугаар захирамжаар амины хашааны зориулалтаар 700 м.кв газрыг нэхэмжлэгчид 5 жилийн хугацаатай эзэмшүүлсэн бөгөөд 2016 оны “Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг сунгах тухай” А/193 дугаар захирамжаар 15 жилийн хугацаатай эзэмшүүлж газар эзэмших эрхийн гэрээ байгуулж, гэрчилгээ олгосон, дээрх иргэн нь тус газраа эзэмшиж эхэлснээс буюу 2010 оноос хойш гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаагүй нь 2013 оны 09 дүгээр сараас 2023 оны 06 дугаар сар хүртэлх сансрын зургаар нотлогдож байна. Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.5, Иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх гэрээний 4.5-д зааснаар тус иргэн нь захираганы акт гарах хүртэлх хугацаанд газрын төлбөрөө төлөөгүй учир 2024 оны А/422 дугаар захирамж үндэслэлтэй ...” гэх агуулгаар нэхэмжлэлийг эс зөвшөөрөн хариу тайлбар гаргажээ.

4.Нийслэл дэх Захираганы хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрээр: Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.5, 40.1.6-д заасныг тус тус баримтлан иргэн Д.Сайнбилэгээс Баянзүрх дүүргийн Засаг даргад холбогдуулан гаргасан “Баянзүрх дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” А/422 дугаар захирамжийн Д.Сайнбилэгт холбогдох хэсгийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах тухай” нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгожээ.

5.Захираганы хэргийн давж заалдаш шатны шүүхийн магадлалаар: Нийслэл дэх Захираганы хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 128/ШШ2024/1041 дүгээр шийдвэрийн ТОГТООХ хэсгийн 1 дэх заалтын “40.1.5,” гэснийг хасч өөрчлөн, бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Отгонбаярын давж заалдаш гомдлыг хангахгүй орхижээ.

6.Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр Улсын дээд шүүх хүлээн авч, Улсын дээд шүүхийн Захираганы хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 001/ШХТ2025/0265 дугаар тогтооолоор “шүүхийн хууль хэрэглээний зөрүүг арилгах”, “эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой” эсэх гэсэн үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.



Хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:

7. Нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс шүүхийн шийдвэр, магадлалыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр хяналтын журмаар гомдол гаргажээ. Үүнд:

7.1. Анхан болон давж заалдах шатны шүүх хууль хэрэглээний зөрүү гаргасан тухайд: Захиргааны байгууллагын шийдвэр гаргах ажиллагааны журмын талаар Захиргааны ерөнхий хуулийн 24-27 дугаар зүйлд заасан бөгөөд захиргааны шийдвэр гаргахдаа бодит нөхцөл байдлыг тогтоох зорилгоор нотлох баримт цуглуулж, сонсох ажиллагаа явуулах нь Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6-д заасан зарчмын агуулгатай нийцнэ. Энэ зарчмын агуулга нь захиргааны байгууллага хэн нэгний эрхэд халдсан шийдвэр гаргахын өмнө үр дагавар нь тусах, эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдхөт этгээдээс урьдчилан тайлбар авч, үзэл бодлоо илэрхийлэх, нотлох баримт гаргаж өгөх боломж олгох, магадгүй нөхцөл байдал өөрчлөгдөх, өөр шийдвэр гаргах үндэслэл байгаа эсэхийг бүрэн дүүрэн нягтлах, ийнхүү мэдэгдсэнээр иргэн, хуулийн этгээдэд гэнэтийн байдлаар асуудлыг шийдвэрлэхгүй байх, иргэний мэдэх эрхийг хангах, улмаар тухайн этгээдийн хувьд хамгийн бага дарамт учруулахуйц аргыг хэрэглэх зорилготой. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хариуцагчаас маргаан бүхий актыг гаргахаас өмнө хийгдсэн ажиллагаа (сонсох ажиллагаа, бодит нөхцөл байдлыг тогтоох)-тай холбоотой нотлох баримт, маргаан бүхий захиргааны актыг мэдэгдсэн баримт гаргуулах шүүгчийн захирамж гарсан боловч хариуцагчаас ийм баримт байхгүй гэдэг бөгөөд энэ нь шийдвэр гаргах ажиллагааны журам ноцтой зөрчигдсэн гэдгийг хариуцагч хүлээн зөвшөөрч буй хэлбэр юм.

7.1.1. Энэ талаар анхан шатны шүүх дүгнэлт өгөөгүй, харин давж заалдах шатны шүүхийн магадлалын 12 дахь хэсэгт дүгнэсэн. Олон нийтийн сүлжээгээр нэхэмжлэгчид сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн баримт нь нотлох баримтын шаардлага хангахгүйгээс гадна уг баримтад нэхэмжлэгчийн нэр байдаггүй. Мөн сонсох ажиллагааны мэдэгдэл хүргүүлсэн баримтад нэхэмжлэгчийн нэрийг бичсэн байх ба цахимаар явуулсан баримтын эх хувь гэж тайлбарладаг боловч хоёр өөр баримт байдаг. Үүнийг давж заалдах шатны шүүх нэг баримт гэж үнэлснээс буруу дүгнэлт өгсөн бөгөөд тус шүүх хэрэгт хамааралгүй баримтыг үнэлж шийдвэр гаргасан нь буруу юм.

7.1.2. Нэхэмжлэгч нь газар эзэмшүүлсэн цаг хугацаанаас хойш газрын төлбөрийг 2024 он хүртэл бүрэн төлж байсан үйл баримтыг давж заалдах шатны шүүх үндэслэлтэй дүгнэсэн боловч маргаан бүхий газарт дэд бүтцийн асуудал шийдэгдээгүй, оршин суух нөхцөл бүрдээгүй буюу тог цахилгааны асуудал шийдэгдээгүй байдлыг анхаарч үзээгүй буюу



хэрэглэх ёстой хуулийг хэрэглээгүй нь хууль хэрэглээний зөрүү гарсан гэж үзэж байна.

7.1.3. Учир нь Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т “Хот, тосгон, бусад суурини нутаг дэвсгэрт газар эзэмшүүлэх, ашиглуулахад дэд бүтцийн хангамж, хөгжлийн чиглэл, ариун цэвэр, эрүүл ахуй, экологи, галын аюулгүй байдлын шаардлага, газар зохион байгуулалт, хот байгуулалтын төлөвлөгөөг үндэслэнэ” гэж зааснаас үзвэл, захиргааны байгууллага анх газар эзэмшүүлэхдээ газрын дэд бүтцийн асуудлыг шийдсэний үндсэн дээр газар эзэмшүүлэхээр байна. Нэг талаас газар эзэмшигч газар эзэмшүүлэх гэрээгээр хүлээсэн үргээ биелүүлэх үүрэгтэй, нөгөө талаас захиргааны байгууллага газрыг зориулалтын дагуу ашиглах боломжоор хангах үүрэгтэй байсан.

7.1.4. Мөн маргаан бүхий газрыг тойрсон 20 гаруй айл эзэмших эрхийн гэрчилгээтэй боловч тухайн хугацаанаас хойш одоог хүртэл нэг ч айл суурьшаагүй, ижил үйл баримттай олон газар эзэмшигчээс нэг иргэний газар эзэмших эрхийг хүчингүй болгож буй явдал нь шударга ёсны зарчимд нийцэхгүй.

7.2. Маргаан нь хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэгч холбогдолтой талаарх гомдлын тухайд: Энэ маргааныг хянан шийдвэрлэх замаар Улсын дээд шүүхийн “Газрын тухай хуулийн зарим заалтыг тайлбарлах тухай” 2008 оны 15 дугаар тогтоолоо тодруулах боломжтой. Учир нь Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгээс үзвэл, газар эзэмших эрхийн гэрчилгээг хэдэн ч удаа сунгах боломжтой байх ба захиргааны байгууллагаас газар эзэмших эрхийг хүчингүй болгохдоо “... зориулалтын дагуу газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэдгийг анх газар эзэмшүүлэх тухай гэрээ хийгдсэнээс хойш ойлгох уу эсхүл газар эзэмшүүлэх гэрээг сунгаж, шинээр газар эзэмшүүлэх гэрээ байгуулсан хугацаанаас хойш ойлгох уу гэдгийг тодруулах боломжтой. Мөн нэхэмжлэгчийн маргаж буй үндэслэл нь үүнтэй төстэй өөр олон маргаан гарахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой тул “зарчмын хувьд ач холбогдолтой” гэж үзэж байна.

7.2.1. Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн дагуу газар эзэмшигч этгээд газраа сунгуулаад 10, 20 .... 100 жил гэх мэт хугацаагаар газар эзэмших эрхтэй байх ба тухайн этгээдийн газрыг Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6-д зааснаар цуцалсан гэж үзье. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдлээр анх гэрээ байгуулсан хугацаанаас тоолох зарчмыг баримталбал газраа эзэмшээд 100 жил болж буй этгээд газраа зориулалтын дагуу ашигласан эсэхэд шүүх хэдэн зуун жилийн өмнөх үйл баримтад дүгнэлт өгөхөөр байна. Иймд энэ маргааныг хүлээн авч, өмнө нь гаргасан шүүхийн тайлбараа

тодруулах боломжтой. Иймд Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.4-т зааснаар шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж өгнө үү гэжээ.

8.Хариуцагчаас нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж бичгээр тайлбарыг ирүүлээгүй байна.

#### ХЯНАВАЛ:

9.Хяналтын шатны шүүхээс шүүхийн шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэв.

Тогооогдсон үйл баримтын тухайд:

10.Баянзүрх дүүргийн Халзангийн ам гэх (тухайн үед 4 дүгээр хороо) байршилд 700 м.кв газрыг “амины хашааны” зориулалтаар 5 жилийн хугацаатай иргэн Д.Сайнбилэгт эзэмшүүлэх эрхийг Баянзүрх дүүргийн Засаг даргын (цаашид “Засаг дарга” гэх) 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 197 дугаар захирамжаар олгож, баталгаажуулсан байна.

11.Улмаар дээрх 700 м.кв газрын эзэмших эрхийн гэрчилгээний хугацааг нэхэмжлэгчийн хүсэлтээр Засаг даргын 2016 оны А/193 дугаар захирамжаар 15 жилийн хугацаагаар сунгаж шийдвэрлэхдээ газрын зориулалтыг “гэр бүлийн хэрэгцээний” гэж өөрчилсөн байх бөгөөд тус шийдвэрийг үндэслэн Баянзүрх дүүргийн (тухайн үед 20 дугаар хороо) Халzan амны 3-1 тоот хаягт “гэр, орон сууцны хашааны” зориулалтаар 15 жилээр эзэмшүүлэхээр, эрхийн улсын бүртгэлийн Э-22040004145 дугаарт бүртгэж, газар эзэмших эрхийн 000083435 дугаартай гэрчилгээг 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдөр олгож, мөн өдөр иргэн, хуулийн этгээдэд газар эзэмшүүлэх 01110-2016/00482 дугаартай гэрээг байгуулжээ.

12.Д.Сайнбилэг нь газар эзэмшүүлэх гэрээнд зааснаар газрын төлбөрийг төлсөн нь газрын төлбөрийн тооцоо нийлсэн актаар тогтоогдох бөгөөд газар дээрээ амины орон сууц захиалан баруулахаар 2019 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр “Сэнжидийн Битүү” ХХК-тай гэрээ байгуулсан нь хэрэгт авагдсан байна.

13.Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт эрх олгогдсон газраа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй, газрын гэрээ, гэрчилгээгээ аваагүй, газрын төлбөрөө хугацаанд



нь төлөөгүй гэх үндэслэлээр “гэр бүлийн хэрэгцээний” зориулалтаар олгогдсон 85 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн A/422 дугаар захирамжаар хүчингүй болгож шийдвэрлэсэнд иргэн Д.Сайнбилэгт олгосон дээрх газар (хавсралтын 57 дугаарт) мөн багтжээ.

Хууль хэрэглээний хувьд:

Энэ хэргийн тухайд, хяналтын шатны шүүхээс шийдвэрлэж, хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь заалтыг “газар эзэмших эрхийн гэрчилгээний төрөл, гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзол”-оор нь ялгаатай тайлбарлаж хэрэглэх эсэх, үүнд ялангуяа гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалт бүхий газрыг тусгайлан авч үзэх эсэх тухай байна.

14.Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т ““газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг”, 27 дугаар зүйлийн 27.1-д “Газрыг энэ хуульд заасан зориулалт, хугацаа, болзолтойгоор гэрээний үндсэн дээр зөвхөн эрхийн гэрчилгээгээр эзэмшүүлнэ” гэж заасан бөгөөд газар эзэмших эрхийн гэрчилгээ нь “гэр бүлийн хамтын хэрэгцээний”, “төрийн байгууллагын”, “аж ахуйн нэгж, байгууллагын” гэсэн төрлтэй байхыг мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.1, 28.1.2, 28.1.3 дахь заалтаар зохицуулсан.

15.Мөн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д “Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан хувийн гэр, орон сууцны хашаа барих зориулалтаар үнэ төлбөргүй эзэмшүүлэх газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байна”, Газрын төлбөрийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн 2-т “Монгол Улсын иргэнийг ахуйн зориулалтаар эзэмшиж, ашиглаж буй 0,07 га хүртэлх хэмжээний газрынх нь төлбөрийн 90 хувиар” газрын төлбөрөөс чөлөөлөхөөр тус тус хуульчилжээ. Иргэн Д.Сайнбилэгт энэ зориулалтаар газар эзэмших эрх үүссэн.

16.Хуулийн дээрх заалтуудад хамаарах гипотез (иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээгээр газар эзэмшүүлэх нөхцөл) нь:

- I.газрын зориулалт нь гэр бүлийн хамтын хэрэгцээнд;
- II.газрын хэмжээ 0,07 га-гаас илүүгүй байх;
- III.эрх олгоходо үнэ төлбөргүй;
- IV.газрын төлбөрөөс 90 хувиар чөлөөлөх зэрэг байна.

17.Газрын тухай хуулийн 2001 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн танилцуулгад “... төр засгаас явуулж байгаа газрын шинэтгэлийг

эрчимжүүлж, иргэдийн газар эзэмших эрхийг өргөтгөх, түүний хэрэгжих нөхцөлийг баталгаажуулах ...” гэх зэргээс үзэхэд, 2002 оны 06 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан Газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын нэг зорилго нь Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх, ингэнсээр иргэдээ амьдран суух болон гэр бүлийн зориулалтаар эзэмших газартай болгож, газар эзэмших эрхийг нь хэрэгжүүлэх нөхцөлийг хөнгөлөн дэмжих агуулга байжээ.

18. Тодруулбал, гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх үндсэн зорилго нь Монгол Улсын иргэдийн хувьд өөрийн гэсэн амьдрах, аминдаа гэр, сууц барих зэргээр гэр бүлийн зориулалтаар газартай болгох хууль зүйн нөхцөлийг бүрдүүлэх явдал байжээ. Энэ эрхийг олгох, баталгаажуулах, хэрэгжилтийг хангах зорилгоор Газрын тухай хуульд газар эзэмшүүлэх “тухайлсан зориулалт” гаргаж, 700 м.кв газрыг, нэг удаа, үнэ төлбөргүйгээр, энэ зориулалтаар олгох, улмаар газрын төлбөрөөс 90 хувиар чөлөөлөх зэргээр “нөхцөл, болзол”-ыг тусгайлан зохицуулжээ.

19. Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгах гэдэг нь газрын зориулалт, ашигтай байдлаас хамааран, газрыг эдийн засгийн эргэлтэд оруулж, түүнийг зохистой ашиглах, хамгаалах харилцааг зохицуулах бөгөөд газар эзэмших “нөхцөл, болзол”-ыг Газрын тухай хуульд заасан газрын зориулалтаас хамаарч ялгаатай хэрэглэхээр байна.

20. Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээний зориулалтаар газар олгох зохицуулалт нь иргэний гэр бүл, эдийн засаг, хөрөнгө чинээ, аж байдлаас шалтгаалан эзэмших байдал нь харилцан адилгүй байж болох, эзэмшил ашиглалтын уян хатан нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн учир иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх нөхцөл шаардлага, мөн иргэн, аж ахуй нэгжид газар эзэмшүүлэх зориулалтыг Газрын тухай хуульд ялгаатай байдлаар зохицуулжээ. Үүний учир нь, тухайн гэр бүлийн наад захын хэрэгцээ, амьжиргааны нөхцөлийг бүрдүүлэх, эдийн засгийн эргэлтийн хөрөнгийн эх үүсгэвэртэй болгох зорилготойгоос гадна гэр бүл төрийн хамгаалалтад байх Монгол Улсын Үндсэн хуулийн үндсэн эрхийн баталгааг хангахад чиглэсэн гэж үзэж болно.

21. Тиймээс гэр бүлийн хамтын хэрэгцээ болон үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар газар эзэмших нөхцөл, болзол тус тусдаа дэглэмтэй бөгөөд үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар газар эзэмшиж буй этгээд газрыг хууль, гэрээнд заасан нөхцөлөөр буюу барилга байгууламж барих зэргээр зориулалтынх нь дагуу ашигтай чанарыг нь гаргаж, эзэмших



учиртай, харин гэр бүлийн хэрэгцээний газарт ийм ижил нөхцөлийг шаардах боломжгүй.

22. Тодруулбал, иргэн, аж ахуй нэгжид үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар эзэмшүүлсэн газрыг ашиглах, үйл ажиллагаа явуулахад тавигдах шаардлага нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар эзэмшихэд тавигдах шаардлагаас нөхцөл, болзлын хувьд ялгаатай, ... өөрөөр хэлбэл, аж ахуйн зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд газар олгож буй зорилго нь бизнесийн хөгжил, ажлын байр бий болгох, эдийн засгийн үр өгөөжтэй байдлыг нэмэгдүүлж хөгжүүлэхэд чиглэгдсэн. Харин иргэдийн гэр бүлийн хэрэгцээний зориулалт нь тэд амьдрал, санхүүгийн нөөц боломжид үндэслэн уг газраа өөрийн мэдэлд байлгаж эзэмших боломжийг олгосон агуулгатай. Тиймээс үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар иргэн, аж ахуй нэгжид олгосон газарт тавигдах нөхцөл шаардлагыг гэр бүлийн хэрэгцээний зориулалт бүхий газарт адилтгахгүй байх нь Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 27 дугаар зүйлийн 27.1, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн зохицуулалтын агуулга, зарчимд нийцнэ.

23. Ийм зориулалтаар газар эзэмшигч этгээд тухайн газрыг гэр бүлийн хэрэгцээндээ байлгаж, амьжиргааны боломжит нөхцөлдөө тохиуулан эзэмшиж байгаа нь Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т заасан "...газрыг зориулалт, нөхцөл, болзлын дагуу" өөрийн мэдэлд байлган газрыг эзэмших гэх хуулийн агуулгад хамаарахаар байна.

24. Гэтэл хариуцагч Засаг дарга уг хуулийн дээрх зорилго, зохицуулалтыг үл харгалзан нэхэмжлэгч иргэнийг "гэр бүлийн хэрэгцээний газраа зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй" хэмээн газар эзэмших эрхийг хүчингүй болгосон нь Газрын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т заасан газар өмчлөх, эзэмших, ашиглахад шударга ёсыг хангах зарчимтай зөрчилдөхийн зэрэгцээ иргэдийн газар эзэмших эрхийг дэмжих, түүний хэрэгжих нөхцөлийг баталгаажуулах хуулийн зорилгод нийцэхгүй.

25. Иргэн Д.Сайнбилэгийн хувьд, тухайн дүүргийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан газарт анх 2010 онд ахуйн зориулалтаар газар эзэмших хүсэлтээ гаргаж, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т зааснаар газар эзэмших эрх нь үүссэн бөгөөд газар эзэмших эрхийн хугацааг 2016 онд 15 жилээр сунгуулсан, мөн газраа зориулалтын дагуу эзэмших нөхцөлөө сайжруулах зорилгоор 2020 онд газар эзэмших, ашиглах гэрээг захиргааны байгууллагатай байгуулсан зэрэг нь тус газар эзэмшигч иргэн газраа олгосон зориулалтаар эзэмшиж, ашиглах хүсэл эрмэлзэлтэй байсан нь илэрхий байх тул нэхэмжлэгчийг орчны төлөвлөлт, дэд бүтцийн хөгжил, өөрийн амьдралын боломжит нөхцөлөөс хамааран газраа зориулалтаар нь эзэмшиж байгаа гэж үзнэ.



26.Иймд Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.6 дахь зохицуулалтыг эрхийн гэрчилгээ эзэмшигч иргэн болон аж ахуйн нэгж, байгууллага (хуулийн этгээд)-ын эзэмшиж буй газрын зориулалтаас хамааран ялгаатай байдлаар тайлбарлаж хэрэглэх нь тус хуулийн агуулга, зорилгод нийцнэ. Өөрөөр хэлбэл, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар иргэн, аж ахуйн нэгжид олгосон газар, гэр бүлийн хамтын хэрэгцээнд зориулан иргэдэд олгосон газар эзэмших эрхийг хэрэгжүүлэх болзол, нөхцөл нь ялгаатай байдлаар тайлбарлагдахаар байхад хариуцагч Засаг дарга Газрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.1.6-д “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй” гэж заасныг баримтлан нэхэмжлэгч Д.Сайнбилэгийн гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газар эзэмших эрхийг хүчингүй болгосон нь хуулийн зорилго, агуулгад нийцэхгүй байна.

27.Анхан болон давж заалдах шатны шүүхээс нэхэмжлэгчийн газар эзэмших эрхийн зориулалтыг харгалзан үзэхгүйгээр “нэхэмжлэгч нь маргаан бүхий газарт ямар нэгэн бүтээн байгуулалт хийгээгүй, хашаа татаагүй газраа ... зориулалтын дагуу 2 жил дараалан ашиглаагүй” гэж дүгнэн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь буруу бөгөөд Газрын тухай хуулийн хэрэглэвэл зохих зүйл, заалтыг хуулийн зорилго, агуулгад нийцүүлэн зөв тайлбарлан хэрэглээгүй нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 106 дугаар зүйлийн 106.2-т заасан шүүхийн шийдвэр хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх шаардлагыг хангагүй байна.

28.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4-т “Улсын дээд шүүх давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хянан үзэх замаар хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангана” гэж зааснаар “иргэнд гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар газар эзэмшүүлэх” тохиолдлыг “иргэн, аж ахуй нэгжид үйлдвэр, үйлчилгээний зориулалтаар” газар эзэмшүүлэх нөхцөл, шаардлагаас ялган тайлбарлаж хэрэглэх нь Газрын тухай хуулийн зорилго, агуулгын хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж шүүх бүрэлдэхүүний олонх дүгнэв.

29.Иймд дээрх үндэслэлээр “Газар эзэмших эрхийн гэрчилгээг хүчингүй болгох тухай” А/422 дугаар захирамжийн Д.Сайнбилэгт холбогдох хэсгийг хууль бус болохыг тогтоож, хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэв.

30.Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.6-д заасны дагуу шүүх бүрэлдэхүүний нэг шүүгч тусгай санал гаргасан болно.



Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2, 127.2.4-т заасныг тус тус удирдлага болгон

ТОГТООХ нь:

1. Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 128/ШШ2024/1041 дүгээр шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 221/МА2025/0196 дугаар магадлалыг хүчингүй болгож, Газрын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3, 4 дүгээр зүйлийн 4.1.3, 29 дүгээр зүйлийн 29.1-д заасныг тус тус баримтлан иргэн Д.Сайнбилэгийн нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж, Баянзурх дүүргийн Засаг даргын 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/422 дугаар захирамжийн Д.Сайнбилэгт холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг баримтлан нэхэмжлэгчээс хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээсүгэй.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоо шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**П.СОЁЛ-ЭРДЭНЭ**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**М.БАТСУУРЬ**

**Ц.ЦОГТ**

**Х.БАТСҮРЭН**

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2025 оны 06 дугаар  
сарын 26-ны өдөр

Дугаар 001/ХТ2025/0066

Улаанбаатар  
хот

Д.Галбаатарын нэхэмжлэлтэй,  
Архангай аймгийн Засаг дарга, тус аймгийн  
Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд  
тус тус холбогдох захиргааны хэргийн тухай

Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны бүрэлдэхүүн:

Даргалагч, шүүгч:  
Шүүгчид:

Г.Банзрагч  
М.Батсуурь  
Х.Батсүрэн  
Ц.Цогт

Илтгэгч: Танхимын тэргүүн  
Нарийн бичгийн дарга:

Д.Мөнхтуяа  
Б.Энхжаргал

Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 109/ШШ2025/0005 дугаар шийдвэр,

Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0223 дугаар магадлалтай,

Захиргааны хэргийн танхимын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 001/ШХТ2025/0245 дугаар хэлэлцүүлэх тогтоолтой хэргийг, хариуцагч Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, гуравдагч этгээд, түүний өмгөөлөгч нарын гомдлоор, нэхэмжлэгч Д.Галбаатар, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Б.Анхбаяр, хариуцагч Архангай аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Гомбодорж (цахимаар), хариуцагч Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга В.Баянтөр, гуравдагч этгээдийн өмгөөлөгч Ц.Бат-Эрдэнэ нарыг оролцуулан хянан хэлэлцэв.

ТОДОРХОЙЛОХ нь:

1. Нэхэмжлэлийн шаардлага: “Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/10 дугаар тогтоол, Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Д.Галбаатарыг албан тушаалаас чөлөөлөх тухай” Б/65, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Б.Баасантотгохыг албан тушаалд томилох тухай” Б/66 дугаар захирамжийг хүчингүй болгуулах”.



2. Нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл: "... сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн анхдугаар хуралдаанаар сумын Засаг даргад нэр дэвшүүлж, дээд шатны Засаг даргад уламжлах асуудлыг хэлэлцсэн бөгөөд миний бие сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Б.Болд-Эрдэнэ санал гаргасны дагуу сумын Засаг даргад нэр дэвшилсэн юм. Тус хуралдаанд сумын Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Эрдэнэжав тус намын бүлгээс Б.Баасантогтохыг сумын Засаг даргад нэр дэвшүүлсэн.

2.1.Б.Баасантогтох нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2-т заасан "... териин албан д 3-аас доошгүй жил ажилласан байх" шаардлагыг хангаагүй байхад сумын хурал уг нэр дэвшигчийн нэрийг хуралд оруулж тухайн нэр дэвшигч дээр санал хураасан нь тус хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1 дэх заалтыг зөрчсөн гэж үзэж байна.

2.2.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1-д "иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч болон аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дахь нам, эвслийн бүлэг, түүнчлэн иргэдийн Нийтийн Хуралд оролцогч дангаараа буюу хамтран энэ хуулийн 56.3, 56.4-т заасан шаардлага хангасан хүнийг Засаг даргад нэр дэвшүүлэхээр санал гаргана" гэж хуульчилжээ.

2.3.Гэтэл энэхүү хуулийн шаардлагыг зөрчиж, сумын хуралд тус хурлын төлөөлөгч биш, намын бүлгээр нэр дэвшүүлсэн нь мөн хуулийн дээрх заалтыг зөрчсөн.

2.4.Дээрх хууль зөрчиж сумын Засаг даргад нэр дэвшүүлсэн, хурал тухайн нэр дэвшүүлсэн хүнийг хүлээн авч санал хураасан үйлдэл нь Архангай аймгийн Цахир сумын Засаг даргад нэр дэвшигч Д.Галбаатар миний эрх ашгийг зөрчсөн үйлдэл болсон гэж үзэж байна" гэх агуулгатай байна.

3.Хариуцаагч Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хариу тайлбар: "... Б.Баасантогтохыг Засаг даргад иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон төлөөлөгч Д.Эрдэнэжав нь нэр дэвшүүлсэн учир Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.5.1-д заасан журмыг зөрчөөгүй.

3.1.Б.Баасантогтох нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасан шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд Цахир сумын

Монгол Ардын намын даргаар 3 жил ажилласан учраас Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу төрийн алба хаасан гэж үзсэн. ...” гэх,

*4.Хариуцагч Архангай аймгийн Засаг даргын хариу тайлбар:* “...Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тухайн сумын Засаг даргад дэвшүүлсэн 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн 25 дугаар албан бичгээр ирүүлсэн баримтуудад үндэслэн Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасан шаардлагыг хангаж байсан тул нэр дэвшсэн этгээд Б.Баасантотгоыг томилсон, мөн хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт заасан хугацаа дууссан тул Цахир сумын Засаг дарга Д.Галбаатарыг чөлөөлсөн захирамжийг хууль ёсны гэж үзэж байна. ...” гэх,

*5.Гуравдагч этгээд Б.Баасантотгооос:* “... нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь миний бие төрийн албанд 3-аас доошгүй жил ажилласан гэж үзэж байгаа тул Архангай аймгийн Цахир сумын Засаг даргад нэр дэвшигдэхэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан. Иймд, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хүлээн зөвшөөрөхгүй...” гэх агуулгатай тайлбарыг тус тус гаргажээ.

#### **6.Хэргийн нөхцөл байдал:**

**6.1.**Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн хуралдаанд сумын Засаг даргад Монгол Ардын намаас Б.Баасантотгоыг, Ардчилсан намаас Д.Галбаатарыг тус тус нэр дэвшүүлж, санал хураалт явуулснаас Б.Баасантотгох 19 төлөөлгчийн буюу 90.5 хувийн санал авсан тул Хурлын мөн өдрийн 01/10 дугаар тогтоолоор сумын Засаг даргад Б.Баасантотгоын нэрийг дэвшүүлж, аймгийн Засаг даргад уламжилсан байна.

**6.2.**Архангай аймгийн Засаг дарга дээрх тогтоолыг үндэслэн 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамжаар “бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон” гэх үндэслэлээр Цахир сумын Засаг даргын албан тушаалаас Д.Галбаатарыг чөлөөлж, мөн өдрийн Б/66 дугаар захирамжаар Цахир сумын Засаг даргын албан тушаалд Б.Баасантотгоыг томилж шийдвэрлэжээ.

#### **7.Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэр:**

**7.1.**Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2.1, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3, 56.3.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх



хэсэгт тус тус заасныг баримтлан нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэхдээ дараах агуулгатай дүгнэлтүүдийг хийсэн байна.

7.1.1.“... 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно” гэж заасан боловч ... уг хууль нь 1994 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөгдөхөөр гарсан, гагцхүү уг хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж байх үе болон шилжилтийн үеийн харилцааг зохицуулахад хэрэглэгдэхээр байна.

7.1.2. ... /Иймд/ гуравдагч этгээд Б.Баасантотгохын Архангай аймгийн Цахир сумын Монгол Ардын намын хорооны даргаар ажилласан хугацааг “төрийн албанд гуруваас доошгүй жил ажилласан” байх хугацаанд хамааруулж, уг шалгуурыг хангасан гэж үзэх үндэслэл тогтоогдсонгүй.

7.1.3. ... Б.Баасантотгох нь 2012 оноос хойш төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд буюу “Төрийн банк” ХК-ийн Архангай салбарын Цахир сумын тооцооны төвийн захирлаар ажилласан боловч энэ нь “төрийн алба”-нд ажилласан хугацаанд хамааралгүй, ... ашгийн төлөө хуулийн этгээд Хөдөлмөрийн гэрээний үндсэн дээр ажиллаж байсан хугацааг “төрийн албан тушаал” хашиж, төрөөс цалин хөлс авч, ажиллах нөхцөл баталгаагаар хангагдан ажилласан гэж үзэх үндэслэлгүй байна.

7.1.4. ... Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1, 35.1.4, 56 дугаар зүйлийн 56.2, 56.3, 56.3.1, 56.3.2, 56.3.3, 56.3.4, 56.3.5-д тус тус зааснаар тухайн сумын Засаг даргад санал болгосон хүнийг буюу нэр дэвшигч Б.Баасантотгох нь дээрх хуулийн шаардлагыг хангаж байгаа эсэхийг хариуцагч нар тодруулах үүрэгтэй.

7.1.5. ... Маргаан бүхий Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/10 дугаар тогтоол, Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/66 дугаар захирамжууд нь дээр дурдсан үндэслэлээр хууль дээдлэх, хуульд нийцсэн байх, хуульд үндэслэлээр зарчмыг зөрчсөн ...” гэжээ.

#### 8. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн магадлал:

8.1. Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагч Архангай аймгийн Засаг даргын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Гомбодорж, хариуцагч Архангай

аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга В.Баянтар, гуравдагч этгээд Б.Баасантогтох, гуравдагч этгээдийн өмгөөлөгч Ц.Бат-Эрдэнэ нарын давж заалдах гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэхдээ дараах агуулгатай дүгнэлтийг хийсэн:

8.1.1.“...Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчин төгөлдөр байна гэх үндэслэлээр дагаж мөрдөхөөр журамласан 1994 оны Төрийн албаны тухай хууль нь хүчингүй болсон байхад бусад хуулиар зохицуулсан “төрийн алба хаасан хугацаа”-тай холбоотой хэм хэмжээг хэрэгжүүлэх бүрт уг хуулийг хэрэглэх хууль зүйн боломжгүй, энэ талаарх анхан шатны шүүхийн дүгнэлт үндэслэлтэй.

8.1.2. ... Засаг дарга нь өндөр хариуцлагатай, төрийн удирдлагыг орон нутагт хэрэгжүүлэгч албан тушаалтан болохынх нь хувьд “төрийн албанд З-аас доошгүй жил ажилласан байх” шаардлагыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2-т тусгайлан заасан байх тул Төрийн албаны тухай хуульд заасан төрийн албанд төрийн албан хаагчаар ажиллаагүй этгээдийг уг шаардлагыг хангасан гэж үзэхгүй” гэжээ.

#### 9.Хяналтын журмаар гаргасан гомдол:

9.1.Хариуцагч Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга В.Баянтареөс 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хяналтын журмаар гаргасан гомдлын агуулга:

9.1.1.“... Б.Баасантогтох нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасан шаардлагыг бүрэн хангаж байгаа бөгөөд Цахир сумын Монгол Ардын намын даргаар гурван жил ажилласан учраас хүчин төгөлдөр үйлчлэлтэй Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд заасны дагуу төрийн алба хаасан гэж үзсэн. Хэдийгээр 1994 оны Төрийн албаны тухай хууль хүчингүй болсон ч 1995 оны Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль хүчингүй болоогүй, мөн хуулиар тухайлсан харилцааг зохицуулсан.

9.1.2. ... 1994 оны Төрийн албаны тухай хуулийг 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр хүчингүй болсонд тооцох тухай хууль батлан хүчингүй болгосон байна. Харин 1995 онд баталсан Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг хүчингүй болгосон аливаа хуулийг Улсын Их Хурлаас батлан гаргаагүй байна.

9.1.3. ... Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтооплын 3 дахь заалт, 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 9



дүгээр тогтоолын 3.1.3-т Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанда шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцохоор зохицуулсан байх тул Б.Баасантотгоыг төрийн албанда 3 жил ажилласан гэж үзэхээр байна.

9.1.4. ... Б.Баасантотгоыг Засаг даргаар томилсны улмаас ... нэхэмжлэгч Д.Галбаатарын хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөөгүй.

9.1.5.Уг хэрэг маргааныг Улсын дээд шүүхээр хэлэлцүүлэх нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т зааснаар эрх зүйн шинэ ойлголт, эсхүл хууль хэрэглээг тогтооход зарчмын хувьд нийтлэг ач холбогдолтой гэж үзэж энэхүү гомдлоо гаргаж байна. Иймд, нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү" гэжээ.

9.2.Гуравдагч этгээд Б.Баасантотгох, түүний өмгөөлөгч Ц.Бат-Эрдэнэ нараас хяналтын журмаар гаргасан гомдлын агуулга:

9.2.1.“... Нэр дэвшигч Б.Баасантотгох нь ... Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаалыг буюу Архангай аймгийн Цахир сумын Монгол Ардын намын хорооны даргын албан тушаалыг 2021 оны 08 дугаар сарын 21-ний өдрөөс 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл 3 жил 2 сар 21 өдөр эрхэлсэн тул Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2-т “... төрийн албанад гурваас доошгүй жил ажилласан” байх хуулийн шаардлагыг хангасан.

9.2.2. ... Анхан шатны шүүхээс “Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн үйлчлэл нь тухайн дагаж мөрдөх гэж буй хууль буюу 1994 оны Төрийн албаны тухай хуулийн зохицуулалтад хамаарлтай бөгөөд уг хэрэг маргаанд дээрх хуулийн зохицуулалтыг хэрэглэх боломжгүй гэж дүгнэсэн нь үндэслэлгүй. Шүүх одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийг хэрэглэх үүрэгтэй.

9.2.3.Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд ... хуулийг дагаж мөрдөх журмын зохицуулалт, 27.1.3-т ... хуулиар тухайлсан харилцааг зохицуулсан байсан хууль, эрх зүйн зохицуулалтын дагуу үүссэн харилцаа, иргэн, хуулийн этгээдийн эрх, үүргийг шинэ хуулийн дагуу хэрхэн хамгаалах, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, өөрчлөх, хүчингүй болсонд тооцох болон сөрөг үр дагаврыг арилгах нөхцөл, арга зам, хариуцлагыг зохицуулах хэлбэр”, 27.1.5-д “өмнөх хууль, эрх зүйн зохицуулалт, тэдгээрийн зарим хэсэг хүчин төгөлдөр үйлчлэх тодорхой нөхцөл, тохиолдол”-ын талаар зааж өгсөн байна.

9.2.4. Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2-т “Хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн”, Жаран гуравдугаар зүйлийн 2-т “Хурлын тогтоол, Засаг даргын захирамж нь хууль тогтоомжид, ... нийцсэн байх” гэж зааснаар Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/10 дугаар тогтоол, Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Д.Галбаатарын албан тушаалаас чөлөөлөх тухай” Б/65, 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Б.Баасантотгохыг албан тушаалд томилох тухай” Б/66 дугаар захирамж нь хууль дээдлэх үндсэн зарчимд тулгуурлан, түүнд нийцүүлэн гарсан байна.

9.2.5. Иймд, Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 109/ШШ2025/0005 дугаар шийдвэр болон давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0223 дугаар магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

10. Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимиын нийт шүүгчийн хуралдааны 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 001/ШХТ2025/0245 дугаар тогтоолоор Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.3, 123.2.4-т заасан үндэслэлээр хяналтын шатны шүүх хуралдаанаар хэргийг хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн.

11. Хариуцагч Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, гуравдагч этгээд, түүний өмгөөлөгч нараас хяналтын журмаар гомдол гаргасныг нэхэмжлэгч Д.Галбаатар, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Б.Анхбаяр нарт 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Ш.Гомбодоржид 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр тус тус цахимаар танилцуулсан байна. Хяналтын журмаар гаргасан гомдолд холбогдуулж аливаа тайлбарыг бичгээр гаргаагүй байна.

#### ХЯНАВАЛ:

12. Хяналтын шатны шүүх дараах үндэслэлээр анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж шийдвэрлэлээ.

13. Анхан болон давж заалдах шатны шүүхээс Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2-т заасан “төрийн албанад гураас доошгүй жил ажилласан” байх шаардлагад холбогдуулан хариуцагч сумын иргэдийн



Төлөөлөгчдийн Хурал, гуравдагч этгээд Б.Баасантогтох нараас гаргасан “... 1994 онд батлагдсан Төрийн албаны тухай хуулийг дагаж гарсан Төрийн албаны хуулийг дагаж мөрдөх журмын тухай /1995 онд батлагдсан/ хуулийг хэрэглэнэ” гэх маргаанд уг хуулийн агуулга, зорилгыг зөв тайлбарлан хэрэглэсэн байна.

14.Төрийн албаны тухай хуулийг 1994 онд, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг 1995 онд тус тус баталсан, уг Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай /1995 оны/ хуулийн 6 дугаар зүйлд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно” гэж заажээ.

15.Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хуулийн зохицуулалт нь шинээр батлагдсан Төрийн албаны тухай хуулийг хэрэгжүүлж эхлэхэд 1994 оноос өмнө улс төрийн намд тодорхой албан тушаал эрхэлж байсан иргэний эрх зүйн байдлыг тогтоох зорилготой, уг хуулийн үйлчлэх хүрээнд хамааралтай бөгөөд уг хуулийн 6 дугаар зүйлд заасан “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албанд шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно” гэх заалт нь 1994 онд хууль батлагдахаас өмнөх хугацаанд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан” иргэдэд хамааралтай гэж үзнэ.

16.Монгол Улсын шинэ Үндсэн хуулийг 1992 онд баталж мөрдсөнөөс хойш төрийн алба, төрийн албан хаагчийн эрх зүйн байдлыг анх удаа 1994 онд хуулиар тогтоосон бөгөөд уг хуульд аливаа улс төрийн намын байгууллагын орон тооны албан тушаалыг “төрийн алба”-нд тооцохор заагаагүй, түүнээс хойш батлагдаж мөрдөгдсөн 2002 оны болон одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2017 оны Төрийн албаны тухай хуулиудад ийм зохицуулалт байхгүй байна.

17.Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хууль нь Төрийн албаны тухай хууль батлагдахаас өмнөх үеийн болон хууль батлагдсанаар үүсэх үр дагаварт шилжилтийн зохицуулалт хийх зорилгоор батлагдсан бөгөөд дагаж мөрдөх журмын тухай хуулийн аль нэг заалтыг эх хуулийн хэм хэмжээний агуулгаас хальж дүгнэхгүй, Төрийн албаны тухай хуульд “Улсын Их Хуралд суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэнийг төрийн алба хаасанд тооцох” агуулгатай заалт байхгүй байхад уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар зөвшөөрсөн гэж үзэх үндэслэлгүй юм.

18.Монгол Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2013 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор “... 2009-2012 онуудад Дорнод аймгийн МАН-ын орон тооны дэд даргаар ажилласан хугацааг төрийн албандаа ажилласан гэж үзэх боломжгүй ... Төрийн албаны хуулийг дагаж мөрдөх журмын тухай /1995 оны/ хуулийг Улсын Их Хурлаас хүчингүй болгоогүй, хуулийн 6 дугаар зүйлд “УИХ-д суудалтай намын байгууллагад орон тооны албан тушаал эрхэлж байсан иргэн төрийн албандаа шилжин ажиллавал намын байгууллагад ажилласан дээрх хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно” гэж заасны дагуу түүнийг төрийн албандаа ажилласнаар тооцох ёстой гэж маргаан үүсгэсэн боловч дээрх хуулийн заалтыг хэрэглэх боломжгүй ...” гэж дүгнэсэн энэ тохиолдолд маргааны үйл баримтууд ижил төстэй байна.

19.Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн их суудлын хуралдааны 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 02 дугаар тогтоолоор “... Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хуулийг батлан гаргасан зорилго, тухайн хуулиар зохицуулах харилцааны мөн чанараас үзэхэд 1994 оны 12 дугаар сарын 30-ны өдөр баталсан Төрийн албаны тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөхөөс өмнөх буюу шилжилтийн үеийн цаг хугацаанд хамаарах харилцааг зохицуулахад хэрэглэхээр байна. 1994 оны Төрийн албаны тухай хууль батлагдахаас өмнө холбогдох албан тушаал эрхэлж байсан иргэдийн эрх зүйн байдлыг тодорхойлох, түүнийг дордуулахгүй байх зорилгоор Төрийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай 1995 оны хууль нь эдүгээ хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа гэж үзэхээр байна. ... 2013-2016 онд Хөвсгөл аймгийн Монгол Ардын намын хорооны даргаар ажилласан хугацаа нь дээрх хуулийн үйлчлэлд хамаарахааргүй байх тул энэ хуулийг баримтлан төрийн албандаа ажилласан хугацаанд тооцох хууль зүйн үндэслэлгүй байна ...” гэж дүгнэжээ.

20.Иймд дээрх хуулийн заалтыг баримталж гуравдагч этгээд Б.Баасантотгохын Монгол Ардын намын хорооны даргаар ажилласан хугацааг төрийн албандаа ажилласнаар тооцох боломжгүй.

21.Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382, 2019 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 09 дүгээр тогтоолуудын хавсралтаар баталсан журмууд нь төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох, төрийн жинхэнэ албан хаагчийн албан үргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгохтой холбоотой харилцааг зохицуулсан байх тул гуравдагч этгээдийн өмгөөлөгчөөс “эдгээр тогтоолуудыг үндэслэн төрийн албандаа 3 жил ажилласан гэж үзнэ” гэх агуулга бүхий гомдлыг хүлээн авах үндэслэлгүй.



22.Иймд, Архангай аймгийн Цахир сумын сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн маргаан бүхий 01/10 дугаар тогтоолоор гуравдагч этгээдийг сумын Засаг даргаар сонгож, томилуулхаар шийдвэрлэсэн болон үүнийг үндэслэн Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/66 дугаар захирамжаар Б.Баасантотгоыг сумын Засаг даргын албан тушаалд томилсон нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2-т заасан “... төрийн албандаа гурваас доошгүй жил ажилласан байх” заалтыг зөрчсөн, түүнчлэн Архангай аймгийн Цахир сумын Засаг даргад нэр дэвшин өрсөлдсөн нэхэмжлэгч Д.Галбаатарын хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж дүгнэн анхан шатны шүүхээс уг тогтоол, захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэсэн нь үндэслэл бүхий болжээ.

23.Харин анхан шатны шүүх нэхэмжлэгчийн “Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” нэхэмжлэлийн шаардлагыг “гуравдагч этгээд Б.Баасантотгоын нэрийг дэвшүүлсэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Засаг даргаар томилсон аймгийн Засаг даргын захирамж хуульд нийцээгүй” гэх үндэслэлээр хангаж шийдвэрлэсэн, маргаан бүхий захирагааны актын хууль зүйн үндэслэлд болон уг захирамжийн улмаас нэхэмжлэгчийн ямар эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөн, зөрчигдсөн талаар дүгнэлт хийгээгүй, энэ алдаа давж заалдах шатны шүүх засаагүй нь буруу байх тул шийдвэр, магадлалын энэ хэсэгт өөрчлөлт оруулах нь зүйтэй байна.

24.Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамжаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус үндэслэн “бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон” гэх үндэслэлээр сумын Засаг даргын албан тушаалд ажиллаж байсан Д.Галбаатарыг чөлөөлжээ.

25.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Засаг даргын бүрэн эрхийн хугацаа 4 жил байна” гэж заасан, нэгэнт нэхэмжлэгч Д.Галбаатарын бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тохиолдолд энэ үндэслэлээр сумын Засаг даргыг чөлөөлсөн аймгийн Засаг даргын шийдвэр хууль бус, нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзэхгүй.

26.Өөрөөр хэлбэл, бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсны улмаас чөлөөлөгдсөн тохиолдолд уг захирамжийг хүчингүй болгож шийдвэрлэснээр нэгэнт хуульд заасан хугацаа дуусгавар болсон Засаг

даргын бүрэн эрх цаашид үргэлжлэх хууль зүйн боломжийг хуулиар олгоогүй тул Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамжийн улмаас нэхэмжлэгч Д.Галбаатарын түүний зөрчигдсөн гэх эрх сэргэх, Засаг даргаар үргэлжлэн ажиллах үр дагавар үүсэхгүй юм.

27.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.3-т "нэхэмжлэл гэж хүн, хуулийн этгээдээс захиргааны хууль бус үйл ажиллагааны улмаас зөрчигдсөн, эсхүл зөрчигдэж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалаулхаар ... үүссэн маргааныг шийдвэрлүүлэхээр захиргааны хэргийн шүүхэд гаргасан өргөдлийг" ойлгоо, 52 дугаар зүйлийн 52.5.1-д "захиргааны акт ...ыг хүчингүй болгуулах ... нэхэмжлэлийн хувьд нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хэрхэн зөрчигдсөн" болохыг тодорхойлох шаардлагатай, түүнчлэн 106 дугаар зүйлийн 106.3.1-д "захиргааны акт ... хууль бус бөгөөд түүний улмаас нэхэмжлэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн болох нь тогтоогдвол түүнийг хүчингүй болгох" гэж заасан тул маргаан бүхий Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамж хууль ёсны эсэх, түүний улмаас нэхэмжлэгч Д.Галбаатарын эрх, хууль ёсны ашиг сонирхол хэрхэн зөрчигдсөн талаар дүгнэлгүй хэргийг шийдвэрлэсэн нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дээрх заалтуудыг зөрчсөн байна.

28.Иймд, дээрх үндэслэлээр анхан болон давж заалдах шатны шүүхийн шийдвэр, магадлалд өөрчлөлт оруулж, Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн Б/65 дугаар захирамжийг хүчингүй болгуулах нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.2.2-т заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1.Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 109/ШШ2025/0005 дугаар шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2025 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 221/МА2025/0223 дугаар магадлалын Тогтоох хэсгийн 1 дэх заалтыг "Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.2.1, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.3.2, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсгийг тус тус баримтлан нэхэмжлэгч Д.Галбаатарын нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, Архангай аймгийн Цахир сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн 01/10 дугаар тогтоол, Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Б.Баасантогтохыг албан тушаалд томилох тухай"



Б/66 дугаар захирамжийг тус тус хүчингүй болгосугай” гэж өөрчлөн, 2 дахь заалтад “Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсгийг баримтлан нэхэмжлэгчийн “Архангай аймгийн Засаг даргын 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн “Д.Галбаатарыг албан тушаалаас чөлөөлөх тухай”  
Б/65 дугаар захирамжийг хүчингүй болгуулах” шаардлагыг хэрэгсэхгүй болгосугай” гэж нэмжк, тогтоох хэсгийн “2”, “3” дугаарыг “3”, “4” гэж өөрчлөн, бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.

2.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.3-т заасныг баримтлан гуравдагч этгээд, түүний өмгөөлөгч нараас хяналтын журмаар гомдол гаргахдаа улсын тэмдэгтийн хураамжид төлсөн 70,200 (далан мянга хоёр зуу) төгрөгийг Төрийн сангийн орлогод хэвээр үлдээж, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.3-т зааснаар хариуцагч улсын тэмдэгтийн хураамж төлөөгүй болохыг дурдсугай.

3.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлийн 127.5-д зааснаар Улсын дээд шүүхийн хяналтын шатны тогтоол нь шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд тогтоолд гомдол гаргахгүй болохыг дурдсугай.

**ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ**

**Г.БАНЗРАГЧ**

**ТАНХИМЫН ТЭРГҮҮН**

**Д.МӨНХТУЯА**

**ШҮҮГЧИД**

**М.БАТСУУРЬ**

**Х.БАТСҮРЭН**

**Ц.ЦОГТ**

